



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 25-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 - 12
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	13 - 66

- 1. Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.01.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/* 14 - 24
- 2. Хүний эрхийн Үндэсний Комиссоос 2023 оны 03 дугаар сарын 29-ний өдөр ирүүлсэн Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэлийн дараах сэдвийг хэлэлцэх. Үүнд:* 24 - 66
 1. Хөдөлмөрлөх эрхийн зарчим асуудал;
 2. Хүүхдийн эрхийн зарим асуудал;

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны 04 дүгээр сарын 25-ны өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Байнгын хорооны дарга Б.Энхбаяр ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 50 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Ганбат, Ц.Мөнх-Оргил, Ц.Мөнхцэцэг, Д.Цогтбаатар;
Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Х.Нямбаатар, Ц.Сэргэлэн, Н.Учрал;

Нэг.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.01.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Д.Цолмон, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах шинжээч Ш.Цолмон, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Х.Эрдэм-Ундрах нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Бат.Баярмаа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт П.Хулан нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Б.Энхбаяр: 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 3.2 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн хуулийн төсөлтэй холбогдуулан бичгээр гаргасан саналаа тайлбарлав.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4

Бүгд: 10
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 3.3 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн хуулийн төсөлтэй холбогдуулан бичгээр гаргасан саналаа тайлбарлав.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтын “22 дугаар зүйлийн 22.2, 22.3 дахь хэсэг” гэснийг “14 дүгээр зүйлийн 14.4, 14.5 дахь хэсэг” гэж өөрчилж, мөн зүйлийн 3 дахь заалт болгон шилжүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 5
Бүгд: 10
50.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Б.Энхбаяр: Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Б.Энхбаяр: Дээрх саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Б.Энхбаяр: 4.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтын 26¹.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“26¹.2.Хуулийн үйлчлэх хугацааг тухайн хуульд зохицуулсан тохиолдолд тус хугацаа дуусмагц хууль хүчингүй болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 4

Бүгд: 10

60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалтын 29.2 дахь хэсгийн “хариуцлагын төрөл, хэмжээ” гэснийг “хариуцлага” гэж өөрчилж, мөн заалтын 29.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“29.4.Энэ хуулийн 14.5-д зааснаас бусад хуулийн төслийг дагалдуулан анхдагч болон шинэчилсэн найруулгын төслийг өргөн мэдүүлэхийг хориглоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 4

Бүгд: 10

60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 8 дахь заалтын 33.7 дахь хэсгийг хасаж, мөн зүйлийн 9 дэх заалтын 38.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“38.4.Хууль санаачлагч худалдаа, хөрөнгө оруулалт, татвар зэрэг бизнесийн орчинд нөлөөлөх хууль тогтоомжийн төсөл боловсруулсан бол энэ хуулийн 40.1.2, 40.1.3-т заасан баримт бичгийг өөрийн албан ёсны цахим хуудас болон эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд 60 хоногоос доошгүй хугацаанд байршуулж, олон нийтээс санал авна. Хуулийн төслийн дэлгэрэнгүй танилцуулгыг англи хэл дээр орчуулж, хамтад нь байршуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 4

Бүгд: 10

60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь заалтын 46¹.1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“46¹ дүгээр зүйл.Хууль тогтоомжийн орчуулга хийх

46¹.1.Шаардлагатай тохиолдолд хууль тогтоомжийн орчуулгыг англи хэлээр хийнэ.

46¹.2.Хууль тогтоомжийн орчуулгын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх бөгөөд хуулиар хориглоогүй бусад эх үүсвэрээс санхүүжүүлж болно.

46^{1.3}.Хууль тогтоомжийн орчуулгын санг бүрдүүлэх, эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд байршуулах ажлыг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцна.

46^{1.4}.Энэ хуулийн 38.4-т заасан хууль тогтоомжийн орчуулгыг тухайн хууль тогтоомж батлагдсанаас хойш 90 хоногийн дотор эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд байршуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 4

Бүгд: 10

60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Б.Энхбаяр: 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн “гарах” гэсний дараа “болон хуулийн албан бус орчуулгын” гэж,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5

Татгалзсан: 5

Бүгд: 10

50.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Б.Энхбаяр: Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 3

Бүгд: 10

70.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Б.Энхбаяр: Дээрх саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 4

Бүгд: 10

60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Б.Энхбаяр: 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтын 1.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.1.Энэ хуулийн зорилго нь хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр /цаашид “хууль тогтоомж” гэх/-ийг санаачлан боловсруулах, хууль тогтоомжийн төсөлд тавигдах шаардлагыг тодорхойлох, олон нийтийн оролцоог хангах, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, батлагдсан хууль тогтоомжийг нийтлэх, сурталчлах, түүний хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалтыг, мөн зүйлийн 3 дахь заалтын 7.3 дахь хэсгийн “энэ хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу” гэснийг, мөн хэсгийн “энэ хуулийн 51 дүгээр зүйлд заасны дагуу нийгмийн” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Б.Энхбаяр: 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “мөн зүйлийн 12.2.10 дахь заалтын “6.3-т” гэснийг “6.3, 6.4-т гэж,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 6 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 6 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Б.Энхбаяр: 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн “9 дүгээр зүйлийн” гэсний өмнө “3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийг,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс бичгээр гаргасан найруулгын саналаар санал хураалт явуулав.

Б.Энхбаяр: 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 15.11 дэх хэсгийн “Монгол Улсын Ерөнхий сайд Улсын Их Хуралд” гэснийг, мөн заалтын 15.12 дахь хэсгийн “үзэл баримтлалын төслийг” гэснийг, мөн зүйлийн 7 дахь заалтын 30.8 дахь хэсгийн “боловч өөр бичилтэй тухайн” гэснийг, 3 дугаар зүйлийн 11 дэх заалтын 51.1 дэх хэсгийн “байдлаар” гэснийг тус тус хасаж, 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтын 22.3 дахь хэсгийн “22.2-т” гэснийг “14.4-т” гэж, мөн хэсгийн “хууль” гэснийг “төсөл” гэж, 3 дугаар зүйлийн 10 дахь заалтын 49.5 дахь хэсгийн “хууль зүй, дотоод хэргийн” гэснийг “хууль зүйн” гэж, мөн зүйлийн 12 дахь заалтын 52.1 дэх хэсгийн “хууль тогтоомжид зохих” гэснийг “түүнд” гэж, мөн хэсгийн “хууль тогтоомжийг системчлэн” гэснийг “системчлэн” гэж, 5 дугаар зүйлийн “мөн хэсгийн” гэснийг “мөн зүйлийн 21.11 дэх хэсгийн” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж үг хэлэв.

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Б.Энхбаяр: 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Б.Энхбаяр нарын гаргасан, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 5
Бүгд: 10
50.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Дэлгэрсайханы “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Б.Энхбаяр: Улсын Их Хурлын гишүүн Б.Дэлгэрсайханы гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Б.Энхбаяр: Дээрх саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 5
Бүгд: 10
50.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Б.Энхбаяр: Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Б.Энхбаяр: Дээрх саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 4

Бүгд: 10

60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Б.Энхбаяр: 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн хуулийн төсөлтэй холбогдуулан бичгээр гаргасан саналаа тайлбарлав.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 4

Бүгд: 10

60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан найруулгын саналаар санал хураалт явуулав.

Б.Энхбаяр: 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “дараах харилцааг зохицуулж буй хуулиудын” гэснийг “хуулийн” гэж, мөн зүйлийн “Хууль зүй, дотоод хэргийн яаманд” гэснийг “хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 32 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Хүний эрхийн Үндэсний Комиссоос 2023 оны 03 дугаар сарын 29-ний өдөр ирүүлсэн Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Ж.Хунан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд С.Зулпхар, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Д.Сүнжид, Х.Мөнхзул, Хүний эрхийн Үндэсний Комиссын Тамгын газрын дарга Ц.Адъяахишиг, Хүний эрхийн Үндэсний Комиссын Хүний эрхийн сургалт, сурталчилгааны хэлтсийн дарга Х.Цэцгээ, Хүний эрхийн Үндэсний Комиссын Судалгаа, дүн шинжилгээ, хяналт шалгалтын хэлтсийн дарга Д.Ёндонжамц, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Н.Баасанжав, Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн, ажлын албаны дарга Д.Баяндүүрэн, Төрийн албаны зөвлөлийн ажлын албаны дарга Г.Билгүүн, Улсын Ерөнхий прокурорын газрын Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн ахлах прокурор, хууль цаазын шадар зөвлөх Б.Баярхүү, Хүний эрхийн Үндэсний Комиссын Гомдол мэдээлэл шалгах хэлтсийн дарга Г.Ууганбаатар, Нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга Д.Баярболд, Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламж үйлчилгээний газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Оюунчимэг, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын хэлтсийн дарга М.Цогтбаатар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүн амын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын хэлтсийн дарга Д.Ганболд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын хэлтсийн дарга Б.Алтантулга, Боловсролын ерөнхий газрын дарга Т.Ням-Очир, Хил хамгаалах ерөнхий газрын Захиргааны удирдлага эрхэлсэн дэд дарга, бригадын генерал Д.Мөнгөнжин, Зэвсэгт хүчний жанжин штабын нэгдүгээр орлогч дарга, хурандаа Ж.Өсөхбаяр, Шүүх шинжилгээний ерөнхий газрын Тэргүүн дэд дарга, цагдаагийн хурандаа Б.Даваа, Онцгой байдлын ерөнхий газрын дэд дарга Д.Намсрай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Захиргаа удирдлагын газрын дарга, хурандаа Б.Дашдаваа, Хууль тогтоомж, дотоод ажлын хэлтсийн дарга, дэд хурандаа

Э.Бадамсамбуу, Нийгмийн сэтгэл зүйн хэлтсийн дарга, хурандаа Ч.Цэнгэлбаяр, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны дарга Х.Нямгэрэл, Нийслэлийн Нийгмийн халамжийн газрын дарга Б.Мөнхбаяр, Мөрдөн байцаах албаны дарга, цагдаагийн хурандаа Б.Батсуурь, Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа И.Батчулуун, Цагдаагийн ерөнхий газрын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, цагдаагийн дэд хурандаа П.Болормаа, Нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга Ө.Ган-Өлзий, Хууль зүйн туслалцааны төвийн захирал В.Оюумаа, Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн хуульч Б.Одончимэг, Нийгмийн даатгалын Ерөнхий газрын Тамгын газрын дарга Б.Батсүх, Жендэрийн үндэсний хорооны нарийн бичгийн дарга бөгөөд ажлын албаны дарга Т.Энхбаяр, Хүний эрхийн Үндэсний Комиссын Судалгаа, дүн шинжилгээ хариуцсан ахлах референт Ч.Ариунаа, Шүүхийн ерөнхий зөвлөлийн ахлах референт Б.Оюуннасан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн референт Э.Ганцэцэг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүн амын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн Ө.Гэрэлт-Од, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн халамжийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн Н.Адъяадорж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын Хөдөлмөрийн харилцааны бодлого зохицуулах газрын шинжээч Т.Мөнгөнцэцэг, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн Д.Оюунгэрэл, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн Д.Баялагцэнгэл, Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Ганзориг, Нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөлийн дарга Т.Ихтамир, Монголын хуульчдын холбооны судалгааны төвийн эрхлэгч Э.Алимаа, Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбооны Хөдөлмөр, нийгмийн бодлогын газрын дарга Ц.Отгонтунгалаг, Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбооны Хүний эрх, хуулийн газрын хуульч М.Саранцацрал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт П.Хулан, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний албаны референт Г.Чингүнжав нар байлцав.

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэлийг Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Ж.Хунан танилцуулав.

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэлийн Хөдөлмөрлөх эрхийн зарим асуудал сэдвээр Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Д.Сүнжид танилцуулга хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир 15 цаг 57 минутаас хуралдааныг даргалав.

Хөдөлмөрлөх эрхийн зарим асуудал сэдвээр хийсэн танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Б.Дэлгэрсайхан, Ш.Адъяаа, Ц.Сандаг-Очир нарын тавьсан асуултад Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Ж.Хунан, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Д.Сүнжид, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд

сайд С.Зулпхар, Төрийн албаны зөвлөлийн ажлын албаны дарга Г.Билгүүн, Боловсролын ерөнхий газрын дарга Т.Ням-Очир нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэлийн Хөдөлмөрлөх эрхийн зарим асуудал сэдвээр хийсэн мэдээллийг сонсов.

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэлийн Хүүхдийн эрхийн зарим асуудал сэдвээр Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Ж.Хунан танилцуулга хийв.

Хүүхдийн эрхийн зарим асуудал сэдвээр хийсэн танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Дэлгэрсайхан, Ц.Сандаг-Очир, Б.Энх-Амгалан нарын тавьсан асуултад Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Ж.Хунан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд С.Зулпхар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын хэлтсийн дарга М.Цогтбаатар, Нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга Д.Баярболд, Боловсролын ерөнхий газрын дарга Т.Ням-Очир, Цагдаагийн ерөнхий газрын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, цагдаагийн дэд хурандаа П.Болормаа нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэлийн Хүүхдийн эрхийн зарим асуудал сэдвээр хийсэн мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 17 цаг 40 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 51 минут үргэлжилж, 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр 17 цаг 41 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Б.ЭНХБАЯР

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордны “Их эзэн Чингис хаан”
танхим
14 цаг 50 минут

**БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Б.Энхбаяр: Б.Дэлгэрсайхан гишүүн ирсэн байна. Б.Пүрэвдорж гишүүн ирцдээ ороорой. Н.Учрал гишүүн Польшийн Ерөнхийлөгчийн арга хэмжээнд байна.

Н.Алтанхуяг гишүүн чөлөөтэй, Л.Мөнхбаатар гишүүн ирсэн, Ш.Раднаасэд гишүүн ирцдээ ороорой. Д.Цогтбаатар гишүүн гадаадад томилолттой. Э.Бат-Амгалан гишүүн ирсэн.

Ц.Мөнх-Оргил гишүүн гадаадад томилолттой. Ц.Сандаг-Очир гишүүн ирсэн. Б.Энх-Амгалан гишүүн ирсэн. С.Бямбацогт гишүүн ирсэн. Ц.Мөнхцэцэг гишүүн гадаадад томилолттой. Ж.Сүхбаатар гишүүн ирсэн. Б.Энхбаяр ирсэн. Д.Ганбат гишүүн томилолттой. Х.Нямбаатар гишүүн томилолттой. Ц.Сэргэлэн гишүүн өвчтэй байна.

Ирцдээ гишүүдээ орох хэрэгтэй байна.

Өнөөдөр Хүний эрхийн Үндэсний Комиссын Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэлийг хэлэлцэх байгаа.

Энэ хүрээнд Хөдөлмөрлөх эрхийн асуудал, Хүүхдийн эрхийн асуудал, Ахмад настны эрхийн асуудал,

Жендерийн эрх тэгш байдлын асуудлын сэдвээр асуудал хэлэлцэх байгаа.

Тийм учраас гишүүд маань ирцдээ орно уу. Хүний эрх ярихаас хойш суух эрхгүй. Бид үүрэгтэй гэж ойлгож байгаа.

Байнгын хорооны гишүүдийнхээ өнөөдрийн айлтгая.

Хууль зүйн байнгын хорооны 2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэгдүгээрт, Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

Засгийн газраас 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр өргөн мэдүүлсэн. Анхны хэлэлцүүлэг явуулна.

Хоёрдугаарт, Хүний эрхийн Үндэсний Комиссоос 2023 оны 03 дугаар сарын 29-ний өдөр ирүүлсэн Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэлийн дараах сэдвүүдийг хэлэлцэнэ.

Дараах сэдвүүдийг хэлэлцэнэ гэдэг нь ямар агуулга хэлж байна вэ гэхээр Хүний эрхийн Үндэсний Комиссын тайлан, илтгэлийг урьд нь ерөнхийд нь бөөнөөр нь багц нэг удаа сонсоод өнгөрчихдөг байсан.

Тэгэхээр хүний эрхийн асуудал дээр Хууль зүйн байнгын хороо онцгой анхаарах учиртай.

Хүний эрхийн Үндэсний Комиссын тайланг ер нь бараг хагас

сонсгол байдлаар, дэлгэрэнгүй сонсож, танилцаж байх ийм үүрэг парламентын өмнө байна гэдэг агуулгаар тайлан, илтгэлийг нэлээн дэлгэрэнгүй сэдэв болгоноор нь хоёр өдөр ярья гэж байгаа юм.

Тэгээд өнөөдөр хөдөлмөрлөх эрх, хүүхдийн эрх, ахмад настны эрх, улс төрийн хүрээн дэх жендэрийн эрх тэгш байдал гэсэн сэдвийг өнөөдөр ярья.

Маргааш Хууль зүйн байнгын хорооны хуралдаанаар халдашгүй чөлөөтэй байх эрхийн асуудал, эрүүдэн шүүхээс ангид байх эрхийн асуудал, иргэний оролцооны эрхийн асуудал, хүний эрхийн хамгаалагчийн эрхийн асуудлыг ярья гэсэн ийм байдалтай байна.

Ингээд хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэгдүгээрт, Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Би ирцээ танилцуулъя. Б.Энхбаяр гишүүн ирсэн байна, Ш.Адъяаа гишүүн ирсэн байна, Э.Бат-Амгалан гишүүн ирсэн байна, С.Бямбацогт гишүүн ирсэн байна, Б.Дэлгэрсайхан гишүүн ирсэн байна, Л.Мөнхбаатар гишүүн ирсэн байна, Б.Пүрэвдорж гишүүн ирсэн байна, Ц.Сандаг-Очир гишүүн ирсэн байна, Ж.Сүхбаатар гишүүн ирсэн байна, Б.Энх-Амгалан гишүүн ирсэн байна.

Д.Ганбат гишүүн гадаад томилолттой, Ц.Мөнх-Оргил гишүүн гадаад томилолттой, Ц.Мөнхцэцэг гишүүн гадаад томилолттой. Д.Цогтбаатар гишүүн гадаад томилолттой, Ц.Сэргэлэн гишүүн чөлөөтэй байна.

Нэг.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.01.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулахтай холбоотой хуралдаанд П.Сайнзориг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Д.Цолмон Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга, Ш.Цолмон Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах шинжээч, Х.Эрдэм-Ундрах Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал гэсэн албан тушаалтнууд оролцож байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай

хуулийн 39.10-д Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ гэж заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье.

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү?

Алга байна.

Гишүүдээс 1 дүгээр зүйлтэй холбогдуулж гаргасан санал байна.

Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга

Г.Тэмүүлэнгээс гаргасан зарчмын зөрүүтэй санал байна.

1.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 3.2-ыг хасах гэсэн санал гаргасан байна.

Г.Тэмүүлэн гишүүн гаргасан саналтай холбогдуулж үг хэлэх үү? Г.Тэмүүлэн гишүүний микрофоныг өгье.

Г.Тэмүүлэн: Хууль тогтоомжийн тухай хууль дээр боловсруулж оруулж ирсэн, Засгийн газраас оруулж ирсэн энэ 3.2 дахь заалттай холбоотой санал гаргаж байгаа.

Тэгэхээр энэ 3.2 дахь заалтыг буюу тухайн жилийн төсвийн тухай хуулийн төслийг боловсруулахад Төсвийн тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд зааснаас бусад харилцааг хуулиар зохицуулна гэсэн заалтыг эхнээсээ оруулж ирсэн байсан.

Энэ агуулга нь юу вэ гэхээр ерөөсөө хууль тогтоомжийн хуульд хамаарагдахгүй Төсвийн тухай хууль, Тогтвортой байдлын тухай хуулийг хоёуланг нь хуулийн үйлчлэлээс гадуур нь гаргаж орхиж байгаа асуудал байгаа.

Тэгэхээр үүгээрээ юу болж байна вэ гэхээр жил жилийн төсвийг өргөн барихад, жил жилийн төсвийн тодотголыг өргөн барихад нөгөө талдаа бүх хууль зүйн талаасаа тавигддаг шалгуур, шаардлага, тухайн аргачлалуудыг мөрдөхгүйгээр өргөн барих энэ зохицуулалт нэг талдаа хуулийн хамгаалалтад орж байна л гэсэн ийм зүйл, заалт болж байгаа юм.

Тэгэхээр бид нэг талдаа энэ төсвийн шинэчлэлийн хүрээнд төсвийн

сайн засаглалыг бий болгох, төсвийнхөө тогтвортой байдлыг бий болгох, эргээд хариуцлагатай болоод ил тод байдлыг бий болгох үүднээс энэ заалтыг хасах ёстой гэж харж байгаа.

Зөвхөн энэ заалтаар ч хязгаарлагдахгүй. Цаашдаа бид одоо мөрдөгдөж байгаа хууль дээр Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.2 дээр заагдсан байгаад байгаа энэ заалтуудыг ч гэсэн хасах ёстой байгаа юм.

Уг нь эхнээсээ ч гэсэн энэ заалтыг хасаж орж ирэх ёстой байсан.

КОВИД-ын үед буюу 2020 оны 4 сард зөвхөн КОВИД-ын тухайн цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулаад л энэ хууль тогтоомжийн төсөл боловсруулахад энэ төсвийн тухай болоод тодотголын тухай асуудлууд, төсийн хүрээний мэдэгдлүүд хамаарахгүй гэдэг зүйл байсан юм.

Тэгтэл одоо 3 жил өнгөрсөн. КОВИД дууссан учраас бид хэвийн нормынхоо горимд орно. Бүх төсөвтэй холбоотой, татвар төлөгчдийн мөнгөтэй холбоотой асуудлууд олон нийтийнхээ хяналт доор орж, ил тод, нээлттэй байдлаараа мэдээлэгдэж явах ёстой гэж харж байгаа.

Тэгэхээр хэрэв бид цаашдаа энэ асуудлыг ингэж хэвээр нь хадгалах юм бол эргээд нэг хоногийн өмнө л Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах, Тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах энэ асуудлууд шууд өргөн баригддаг. Эргээд ямар нэг хууль тогтоомжийн хуулиар, аргачлалаар нь боловсруулагдахгүйгээр, олон нийтэд мэдээлэгдэхгүйгээ, танилцагдахгүйгээр Улсын Их Хурал шууд хэлэлцэх ийм л нөхцөл байдал руу орж байгаа.

Тэгэхээр Монгол Улсад бүх хууль Хууль тогтоомжийн хуулиар явах ёстой. Тэр дундаа төсөв хамгийн чухал асуудал. Ард түмний эрх ашиг хөндөгдсөн асуудал. Ард түмнээс үл маргах журмаар татвар төвлөрүүлж байгаа асуудлыг бид захиран зарцуулах харилцаан дээр олон нийтийн оролцоо болоод иргэдийн хяналт тавих, тэр дундаа Улсын Их Хурлын хяналт тавих эрх нь энд хангагдах ёстой гэж харж байгаа.

Тэгэхээр энэ үүднээсээ Хууль зүйн байнгын хорооны гишүүдийг энэ саналыг дэмжиж өгөөрэй гэж хүсэж байна.

Б.Энхбаяр: Г.Тэмүүлэн гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй түрүүн уншсан саналын томъёоллыг дэмжье гэсэн саналын томъёоллоор.

Дахиад уншихъя. Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 3.2 дахь хэсгийг хасах гэсэн саналын томъёоллыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Төсвийн байнгын хорооны даргын саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

60.0 хувийн саналаар төсөл дэмжигдлээ.

Г.Тэмүүлэн гишүүний гаргасан хоёр дахь зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг уншиж сонсгоё.

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 3.3 дахь хэсгийг хасах гэсэн санал гаргасан байна.

Г.Тэмүүлэн гишүүн тайлбар хэлэх үү? Г.Тэмүүлэн гишүүний микрофоныг өгье. Санал гаргасан гишүүн тайлбар хэлье.

Г.Тэмүүлэн: 3.3 дахь асуудал бол бас зарчмын хувьд.

Ер нь Улсын Их Хурлын гол үүрэг ерөөсөө аливаа хууль тогтоомж болоод түүний гүйцэтгэл, түүн дээр хяналт тавих асуудлууд байдаг.

Тэгэхээр Монгол Улсын хөгжлийн бодлогыг боловсруулах үүрэг нь Засгийн газар дээр байгаа ч гэсэн түүн дээр тодорхой хэмжээнд хяналт тавих. Үүн дотроо ил тод болоод нээлттэй байдлыг бий болгох асуудлууд байгаа.

Тэгэхээр хөгжлийн бодлогыг боловсруулахад ч гэсэн энэ Хууль тогтоомжийн хуулийнхаа хүрээнд тухайн боловсруулалтын шатанд, төлөвлөлтийн шатанд эргээд ил тод байдлыг хангах, оролцоог хангах, хяналтыг бүрдүүлэх асуудал зарчмын хувьд байх ёстой асуудал.

Тэгэхээр хөгжлийн бодлогыг боловсрууллаа гээд энэ асуудлыг хууль тогтоомжийн хуулиас гадна гаргаж ямар нэг, одоо юу гэдэг юм Хууль тогтоомжийн хуулийн хүрээнд бус аргачлалыг мөрдөхгүйгээр ингэж оруулж ирэх нь буруу л гэж харж байгаа.

Тэгэхээр бид цаашдаа ер нь аливаа хөгжлийн бодлогыг тухайн тэр бодлого, төлөвлөлттэйгөө уялдуулах, төсөвтэй уялдуулах, бодлогынхоо үндсэн бичгийн зорилт, зорилготой уялдуулахад тооцоо, судалгаа, үндэслэл зайлшгүй шаардлагатай.

Тэгэхээр энэ хэрэв орох юм бол цаашдаа хөгжлийн бодлогыг

боловсруулахад ямар нэг үндэслэл хэрэггүй болно, тооцоо судалгаа хэрэггүй болно, дүн шинжилгээ хийх хэрэггүй болно. Тухайн тэр хууль тогтоомжийн хуулийн боловсруулалт дээр ямар нэг оролцоо хяналтын асуудлууд байхгүй болно л гэж харж байгаа.

Тэгэхээр энэ зарчмын хувьд Хууль тогтоомжийн хуулиар байх ёстой. Монгол Улсад мөрдөгдөж байгаа, боловсруулагдаж байгаа бүх хууль болгон Хууль тогтоомжийнхоо хуулийн хүрээнд байх ёстой.

Энэ зөвхөн 2020 оны 4 сард КОВИД-ын нөхцөл байдалтай уялдуулж Улсын Их Хурал тодорхой хэмжээний зохицуулалтыг гаргаж байсан бол одоо үүнийгээ бүрэн өөрчлөх ёстой байтал бүр бүтэн хуулиар авч хамгаалалтад оруулах нь буруу л гэж харж байгаа.

Тэгэхээр үүнийг Та бүхнийг дэмжихийг хүсье.

Б.Энхбаяр: Нэлээн олон гишүүд, Г.Тэмүүлэн гишүүн нарын гишүүд энэ төсвийн хуулийн шинэчлэлийн хүрээнд төсвийг ил тод болгох, иргэд олон нийтээр хэлэлцүүлдэг болох, хяналттай болох, тооцоо судалгаатай болох чиглэлд хуулийн төсөл өргөн барьж, төсвийн шинэчлэлийн асуудлыг дэвшүүлж явж байгаа.

Энэ хүрээнд Хууль тогтоомжийн хууль ч гэсэн, ялангуяа энэ төсөвтэй холбоотой хэсэг тэр Их Хурлын гишүүдийн өргөн барьсан хуулийн хүрээнд ингэж ил тод хэлэлцэгддэг байх чиглэлийн өөрчлөлт явна.

Тийм учраас Засгийн газраас өргөн барьсан Хууль тогтоомжийн тухай хууль орсон энэ асуудлыг хасах нь зүйтэй гэдэг саналыг гаргасан байна.

Тэгээд Та бүхэнд дахиж саналын томъёоллыг уншиж өгье.

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 3.3-ыг хасах гэсэн саналын томъёолол гаргасан.

Энэ томъёоллыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

60.0 хувиар санал дэмжигдлээ.

Гурав дахь санал. Миний гаргасан санал байна.

Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтын “22 дугаар зүйлийн 22.2, 22.3 дахь хэсэг” гэснийг “14 дүгээр зүйлийн 14.4, 14.5 дахь хэсэг” гэж өөрчилж, мөн зүйлийн 3 дахь заалт болгон шилжүүлэх.

Санал гаргасан миний бие. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Ж.Сүхбаатар гишүүн санал гаргая. Энэ хууль доторх техникийн засваруудыг хийх шаардлагатай байна. Хууль хоорондын нийцлийг хангах гээд байна шүү дээ. Ж.Сүхбаатар сайд аа.

Ж.Сүхбаатар: Би сая энд хүний эрхийн асуудлаарх материал уншиж байгаад, тэгээд тэтгэврийн асуудал дээр анхаарал хандуулж байгаад юу яачихлаа саналаа өгч чадсангүй.

Б.Энхбаяр: Санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн санал гаргаж байна гэж ойлголоо.

Ж.Сүхбаатар гишүүний гаргасан горимын саналаар санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/ Гишүүд анхааралтай байгаарай.

60.0 хувийн саналаар санал хураалтыг хүчингүй болголоо.

Одоо дахиад түрүүний уншсан төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтын “22 дугаар зүйлийн 22.2, 22.3 дахь хэсэг” гэснийг “14 дүгээр зүйлийн 14.4, 14.5 дахь хэсэг” гэж өөрчилж, мөн зүйлийн 3 дахь заалт болгон шилжүүлэх гэсэн саналын томьёоллыг дэмжье гэдгээр санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

60.0 хувиар санал дэмжигдлээ.

4 дэх санал. Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтын 26^{1.2} дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“26^{1.2}.Хуулийн үйлчлэх хугацааг тухайн хуульд зохицуулсан тохиолдолд тус хугацаа дуусмагц хууль хүчингүй болно.”

Санал гаргасан Их Хурлын гишүүн Б.Энхбаяр. Дэмжье гэдэг саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

60.0 хувиар санал дэмжигдлээ.

5 дахь санал. Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалтын 29.2 дахь хэсгийн “хариуцлагын төрөл, хэмжээ” гэснийг “хариуцлага” гэж өөрчилж, мөн заалтын 29.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“29.4.Энэ хуулийн 14.5-д зааснаас бусад хуулийн төслийг дагалдуулан анхдагч болон шинэчилсэн найруулгын төслийг өргөн мэдүүлэхийг хориглоно.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

60.0 хувиар санал дэмжигдлээ.

6 дахь санал. Төслийн 1 дүгээр зүйлийн 8 дахь заалтын 33.7 дахь хэсгийг хасаж, мөн зүйлийн 9 дэх заалтын 38.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“38.4.Хууль санаачлагч худалдаа, хөрөнгө оруулалт, татвар зэрэг бизнесийн орчинд нөлөөлөх хууль тогтоомжийн төсөл боловсруулсан бол энэ хуулийн 40.1.2, 40.1.3-т заасан баримт бичгийг өөрийн албан ёсны цахим хуудас болон эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд 60 хоноогоос доошгүй хугацаанд байршуулж, олон нийтээс санал авна. Хуулийн төслийн дэлгэрэнгүй танилцуулгыг англи хэл дээр орчуулж, хамтад нь байршуулна.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

60.0 хувиар санал дэмжигдлээ.

7 дахь санал. Төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь заалтын 46^{1.1} дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“46¹ дүгээр зүйл.Хууль тогтоомжийн орчуулга хийх

46¹.1. Шаардлагатай тохиолдолд хууль тогтоомжийн орчуулгыг англи хэлээр хийнэ.

46¹.2. Хууль тогтоомжийн орчуулгын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх бөгөөд хуулиар хориглоогүй бусад эх үүсвэрээс санхүүжүүлж болно.

46¹.3. Хууль тогтоомжийн орчуулгын санг бүрдүүлэх, эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд байршуулах ажлыг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцна.

46¹.4. Энэ хуулийн 38.4-т заасан хууль тогтоомжийн орчуулгыг тухайн хууль тогтоомж батлагдсанаас хойш 90 хоногийн дотор эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд байршуулна.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулья. Санал хураалт. /алх цохив/

60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Санал хураалт явуулья.

Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүдийн бичгээр гаргасан саналаар санал хураалтыг явуулья.

Төслийн 2 дугаар зүйлийн “11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн “гарах” гэсний дараа “болон хуулийн албан бус орчуулгын” гэж,” гэснийг хасах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр. Дэмжье гэсэн

саналын томъёоллоор санал хураалт явуулья. Санал хураалт. /алх цохив/

Б.Пүрэвдорж гишүүн санал гаргая.

Б.Пүрэвдорж: Би сая яг энэ дээр санал өгөх гэж байсан чинь ийшээ гишүүнтэй юм яриад яасангүй. Тэгээд дахиад энэ саналыг хүчингүй болгож өгөөч. Би дэмжиж байгаа юм, уг нь.

Б.Энхбаяр: Б.Пүрэвдорж гишүүний гаргасан, санал хураалтыг хүчингүйд тооцох саналаар санал хураалт явуулья. Санал хураалт. /алх цохив/

Сая техникийн асуудал үүслээ. Ш.Адъяаа гишүүн та өөр юунд. Саяын санал хураалтыг цуцалъя. Яагаад гэхээр сая техникийн саатал гарсан.

Б.Пүрэвдорж гишүүний гаргасан горимын саналаар санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн саналаар санал хураалт явуулья. Санал хураалт. /алх цохив/

70.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Дахин санал хураалт явуулна.

Төслийн 2 дугаар зүйлийн “11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн “гарах” гэсний дараа “болон хуулийн албан бус орчуулгын” гэж,” гэснийг хасах гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулья. Санал хураалт. /алх цохив/

60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Санал хураалтыг явуулж эхэлъе.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан гаргасан санал байна.

Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтын 1.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.1.Энэ хуулийн зорилго нь хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр /цаашид “хууль тогтоомж” гэх/-ийг санаачлан боловсруулах, хууль тогтоомжийн төсөлд тавигдах шаардлагыг тодорхойлох, олон нийтийн оролцоог хангах, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, батлагдсан хууль тогтоомжийг нийтлэх, сурталчлах, түүний хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

70.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Дараагийн санал хураалт.

Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалтыг, мөн зүйлийн 3 дахь заалтын 7.3 дахь хэсгийн “энэ хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу” гэснийг, мөн хэсгийн “энэ хуулийн 51 дүгээр зүйлд заасны дагуу нийгмийн” гэснийг тус тус хасах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна.

4 дүгээр зүйлтэй холбоотой нэг санал хураалт байна.

Төслийн 4 дүгээр зүйлийн “мөн зүйлийн 12.2.10 дахь заалтын “6.3-т” гэснийг “6.3, 6.4-т гэж,” гэснийг хасах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

70.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна.

Тухайн зүйл дээр гишүүдээс гаргасан санал алга байна.

Хуулийн төслийн 6 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна.

Санал хураалт явуулъя. Гишүүдээс бичгээр гаргасан нэг санал байна.

Төслийн 6 дугаар зүйлийн “9 дүгээр зүйлийн” гэсний өмнө “3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийг,” гэж нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

70.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүдийн бичгээр гаргасан найруулгын саналаар санал хураалт явуулъя.

Найруулгын санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 15.11 дэх хэсгийн “Монгол Улсын Ерөнхий сайд Улсын Их Хуралд” гэснийг, мөн заалтын 15.12 дахь хэсгийн “үзэл баримтлалын төслийг” гэснийг, мөн зүйлийн 7 дахь заалтын 30.8 дахь хэсгийн “боловч өөр бичилттэй тухайн” гэснийг, 3 дугаар зүйлийн 11 дэх заалтын 51.1 дэх хэсгийн “байдлаар” гэснийг тус тус хасаж, 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтын 22.3 дахь хэсгийн “22.2-т” гэснийг “14.4-т” гэж, мөн хэсгийн “хууль” гэснийг “төсөл” гэж, 3 дугаар зүйлийн 10 дахь заалтын 49.5 дахь хэсгийн “хууль зүй, дотоод хэргийн” гэснийг “хууль зүйн” гэж, мөн зүйлийн 12 дахь заалтын 52.1 дэх хэсгийн “хууль тогтоомжид зохих” гэснийг “түүнд” гэж, мөн хэсгийн “хууль тогтоомжийг системчлэн” гэснийг “системчлэн” гэж, 5 дугаар зүйлийн “мөн хэсгийн” гэснийг “мөн зүйлийн 21.11 дэх хэсгийн” гэж тус тус өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах

тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү?

Б.Пүрэвдорж гишүүнээр тасаллаа.
Б.Пүрэвдорж гишүүн асуултаа асууя.

Б.Пүрэвдорж: Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд Улсын Их Хурлын гишүүн л санаачилж өөрчлөлт оруулах заалттай.

Гэтэл үүнийг Засгийн газар оруулж ирээд яг энэ парламентын хууль тогтоох үйл ажиллагаанд шууд хөндлөнгөөс ороод явах боломжийг энэ хуулиар гаргаж өгч байна.

Тийм учраас Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хууль тогтоомжийн хуульд өөрчлөлт оруулахтай холбогдуулан өргөн барьсан энэ асуудлыг тэр чигээр нь хасах ийм саналыг гаргамаар байна.

Б.Энхбаяр дарга бас яг энэ асуудлаар санал гаргаж байх шиг байна.

Тийм учраас би хамтдаа энэ асуудлаар. Ер нь парламент өөрөө энэ дэгийн тухай хуулиа, яаж хуралдахаа, яаж асуудлаа хэлцгээ, ямар процедураар явахаа бүгдийг нь өөрөө шийдэх бүрэн эрхтэй. Гэтэл энэ дээр институт хоорондын зөрчил бий болгохоор асуудал оруулж ирж байгаа.

Тийм учраас энэ дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай асуудлыг бүхлээр нь хасах саналтай байгаа гэдгийг хэлье.

Б.Энхбаяр: Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж дууслаа.

Одоо хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүдийн бичгээр гаргасан саналаар санал хураалт явуулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Б.Энхбаяр. Санал хураалт. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Б.Дэлгэрсайхан гишүүн горимын санал гаргая.

Б.Дэлгэрсайхан: Сая техникийн алдаа гарчих шиг боллоо. Уг нь би дэмжиж дарсан. Тэгээд минийх гарсангүй. Дахин санал хурааж өгнө үү.

Б.Энхбаяр: Б.Дэлгэрсайхан гишүүний гаргасан саналаар саяын санал хураалтыг хүчингүйд тооцъё гэсэн саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

60.0 хувийн саналаар дэмжигдэж, санал хураалтыг хүчингүйд тооцлоо.

Ингээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн Б.Пүрэвдорж, Б.Энхбаяр нарын гишүүдийн гаргасан саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Б.Пүрэвдорж гишүүний микрофон ажилласангүй. Энэ гаргасан саналынхаа эсрэг гараад байна. Б.Пүрэвдорж гишүүн гарга.

Б.Пүрэвдорж: Б.Дэлгэрсайхан гишүүн учрыг нь мэдэхгүй юм асууж байх хооронд буруу дарагдчихлаа.

Дахиж санал хураалгаж өгнө үү.

Б.Энхбаяр: Б.Дэлгэрсайхан гишүүн буруугүй гэдгийг би хурал даргалж байсны хувьд мэдэж байна.

Б.Пүрэвдорж гишүүний гаргасан горимын саналаар санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

60.0 хувийн саналаар санал хураалтыг хүчингүйд тооцлоо.

Дахиад Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах саналаар санал хураалт явуулъя. Гишүүд анхааралтай байгаарай. Санал хураалт. /алх цохив/

60.0 хувиар санал дэмжигдлээ.

Одоо Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна.

Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүдээс бичгээр гаргасан саналаар санал хураая. Нэг санал байна.

Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгээс гаргасан санал байна.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн санал байна.

Г.Тэмүүлэн гишүүн гаргасан саналтай холбогдуулж үг хэлэх үү? Г.Тэмүүлэн гишүүн үг хэлье.

Г.Тэмүүлэн: Тэгэхээр Хууль тогтоомжийн хууль дээр дагалдуулж Засгийн газрын зүгээс Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг өргөн барьж оруулж ирсэн.

Энэ дээр юу орж ирж байна вэ гэхээр ерөөсөө гол үндсэн Тогтвортой байдлын тухай хуулийн 8 дугаар зүйл буюу Төсвийн тусгай шаардлагын үйлчлэлийг түр түдгэлзүүлэх тохиолдол гэж заалт байдаг.

Энд тусгагдсан “түдгэлзүүлэх”, “түдгэлзүүлж”, “түдгэлзүүлснээс” гэдгийг “зогсоох”, “зогсоож”, “зогсоосон”, “зогсоосноос” гэдэг үгээр сольж байгаа.

Тэгэхээр утга агуулгын хувьд “түдгэлзүүлэх”, “зогсоох” гэдэг хоёр бол нэг талдаа хоёр өөр утга, агуулгатай асуудлууд.

Бид бүхний хувьд энэ Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн гол үндсэн зорилго нь төсвийг тогтвортой байлгах, тогтвортой байдлыг нь хангах, ирээдүйд учрах ямар нэгэн санхүүгийн эрсдэлээс хамгаалах. Нөгөө талдаа

шийдвэр гаргагчид өөрсдийн үзэмжээр төсөв дээр ямар нэг шийдвэр гаргахыг хязгаарлах л ийм хууль байгаа юм.

Тэгэхээр утга, агуулгын хувьд 8 дугаар зүйл дээр тусгагдсан байгаа “түдгэлзүүлэх” гэдэг тохиолдолд угаасаа түр хугацаагаар түдгэлздэг. Зөвхөн тухайн жил. Тухайн жилийнх нь дотоодын нийт бүтээгдэхүүнийх нь өсөлт өмнөх жилтэй харьцуулахад 0 байвал, эсвэл түүнээс бага байвал. Эсвэл тухайн жилийнх нь дотоодынх нь нийт бүтээгдэхүүний 5.0 хувь буюу түүнээс дээш хэмжээнд юу гэдэг юм хор уршиг ч гэдэг юм уу, ямар нэг эрсдэлийн асуудлууд төсвөөс нэмж шаардагдах санхүүжилт нь илүү гарахаар байвал гэсэн ийм л хоёр шаардлага дээр байгаа юм.

Тэгэхээр тухайн жилийнх. Тэгэхээр энэ чинь яг энэ тухайн жилийнхээ хугацаанд буюу тэр хугацаагаараа түдгэлзүүлэх асуудлыг зогсоох гэдэг бол өөрөө байж болохгүй асуудал л гэж харж байгаа юм.

Тэгэхээр би нэг талдаа Тогтвортой байдлынхаа тухай хууль дээр ингэж үзэмжээр гар хүрч, үг, үсгийг нь өөрчлөх, агуулгыг нь алдагдуулах буруу гэж харж байгаа.

Тэгэхээр анх 2010 онд энэ хууль батлагдсан. Тухайн үндсэн бичигдсэн байдлаараа буюу “түдгэлзэх”, “түдгэлзүүлэх” гэдэг нэр томъёогоор байх нь хууль зүйн талаас зөв өө гэж үзэж байгаа.

Б.Энхбаяр: Г.Тэмүүлэн гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулья.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаая гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Санал хураалт явуулъя.

Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүдийн бичгээр гаргасан саналаар санал хураалт явуулъя. Нэг санал байна.

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн найруулгын санал байна.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “дараах харилцааг зохицуулж буй хуулиудын” гэснийг “хуулийн” гэж, мөн зүйлийн “Хууль зүй, дотоод хэргийн

яаманд” гэснийг “хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад” гэж тус тус өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

70.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна.

Тухайн зүйл дээр гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна.

Тухайн зүйл дээр гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг Ц.Сандаг-Очир гишүүн танилцуулах уу. Ц.Сандаг-Очир гишүүн танилцуулъя.

Эхний асуудлыг хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Дараагийн асуудалдаа орёе.

Хоёр.Хүний эрхийн Үндэсний Комиссоос 2023 оны 03 дугаар сарын 29-ний өдөр ирүүлсэн Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх Хүний эрхийн Үндэсний Комиссын 22 дахь илтгэлийг хэлэлцье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хороо болон холбогдох бусад Байнгын

хороо хаврын ээлжит чуулганы хугацаанд хэлэлцэнэ гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112.5-д энэ хуулийн 112.2-т заасан Засгийн газрын тайлан, илтгэлийг Ерөнхий сайд, холбогдох байгууллагын тайлан, илтгэл, мэдээллийг тухайн байгууллагын дарга Байнгын хороо, нэгдсэн хуралдаанд танилцуулна.

Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж байгаа тайлан, илтгэл, мэдээлэл, Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлж болно гэж заасан байна.

Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэлийн талаарх товч танилцуулгыг Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Ж.Хунан танилцуулна.

Ж.Хунан дарга 2 номерын микрофонд танилцуулья.

Ж.Хунан: Эрхэм хүндэт Хууль зүйн байнгын хорооны дарга, гишүүд, хуралдаанд оролцогч төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.12, 9 дүгээр зүйлийн 9.1, 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3.5-д заасан чиг үүргийн дагуу комиссоос Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний талаарх 22 дахь илтгэлийг Улсын Их Хурлын даргад 2023

оны 03 дугаар сарын 29-ний өдөр өргөн мэдүүлсэн.

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэлийг комиссоос 2022 онд хийж гүйцэтгэсэн судалгаа, хяналт шинжилгээ, комисст иргэдээс ирүүлсэн гомдол, мэдээлэл болон комиссын гишүүний хийсэн хяналт шалгалтын үр дүн, төр, иргэний нийгэм, олон улсын байгууллагуудын албан ёсны тайлан, мэдээлэл, бусад эх сурвалжид үндэслэн боловсруулж, Улсын Их Хуралд холбогдох шийдвэр гаргуулахаар 42 саналыг хүргүүлээд байна.

Илтгэлийн “Халдашгүй чөлөөтэй байх эрх” сэдвийн хүрээнд сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлгүй баривчлах ажиллагаан дахь хүний эрхийн асуудал, цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ дэх хүний эрхийн асуудал, бүх насаар хорих болон ганцаарчлан хорих ял эдлүүлж буй байдал, эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ ба хүний эрхийн асуудал, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны үед хүнийг саатуулах талаарх эрх зүйн орчинд хийсэн дүн шинжилгээг танилцуулсан болно.

Иргэний оролцооны эрх зүйн зохицуулалт сэдвийн хүрээнд хэвлэл мэдээллийн эрх чөлөөний эрх зүйн зохицуулалт, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний эрх зүйн зохицуулалт, төрийн бус байгууллагын эрх зүйн зохицуулалтад дүн шинжилгээ хийлээ.

Илтгэлийн Хөдөлмөрлөх эрхийн зарим асуудал сэдвийн хүрээнд төрийн албан хаагчийн эрх зүйн байдал, хууль тогтоомжийн өөрчлөлт, төрийн үйлчилгээний албан хаагчийн хөдөлмөрлөх эрхийн зарим асуудал, төрийн тусгай албан хаагчийн хөдөлмөрлөх эрхийн зарим асуудал,

хоригдлын хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг хөндлөө.

Илтгэлийн хүүхдийн эрхийн зарим асуудал сэдвийн хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн дотуур байр дахь хүүхдийн эрхийн асуудлыг.

Мөн Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйл ажиллагааны өнөөгийн нөхцөл байдалд хийсэн хяналт шалгалтын үр дүнг танилцуулсан.

Илтгэлийн Ахмад настны эрхийн хэрэгжилт сэдвийн хүрээнд ахмад настны нийгмийн хамгаалал, ахмад настны эрүүл мэндээ хамгаалуулах эрх, ахмад настны хөдөлмөрлөх эрх, ахмад настны ялгаварлан гадуурхалт, хүчирхийллээс ангид байх эрх, ахмад настны хөгжих эрхийн хэрэгжилтийг хөндсөн.

Илтгэлийн Хүний эрх хамгаалагчийн эрх, хамгаалалт сэдвийн хүрээнд хүний эрх хамгаалагчийн нөхцөл байдал, хүний эрх хамгаалагчийн эрх зөрчигдөж буй байдал, хүний эрх хамгаалагчийг хамгаалах тогтолцоог бэхжүүлэх шаардлага, тулгамдаж буй асуудлуудыг тусгалаа.

Улс төрийн хүрээн дэх жендэрийн эрх тэгш байдал сэдвийн хүрээнд улс төрийн хүрээн дэх жендэрийн эрх тэгш байдлын талаарх хууль тогтоомжийн зохицуулалт, бодлогын баримт бичиг, түүний хэрэгжилт, эрэгтэй, эмэгтэй хүний улс төрийн үйл ажиллагаанд оролцох тэгш эрх, тэгш боломжийг хангаж буй байдал, нийтлэг зөрчил, түүний шийдвэрлэлтийг танилцуулсан.

Мөн энэ удаагийн илтгэлээр Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүний шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ болон хэвлэл

мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн загвар хуулийн төсөл болон түүнийг дагалдах хуулиудын загвар төслийг танилцуулсан.

Эрхэм хүндэт гишүүд ээ,

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлийг хэлэлцэж холбогдох шийдвэрийг гаргаж өгнө үү. Баярлалаа.

Б.Энхбаяр: Ж.Хунан даргад баярлалаа.

Би түрүүн эхэлж хэлсэнчлэн Хүний эрхийн Үндэсний Комиссын Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх тайлан илтгэлийг урьд нь нэг хамтатгаад сонсоод явчихдаг байсныг 2 өдрийн турш Хууль зүйн байнгын хороо хагас сонсгол хэлбэрээр анх удаа зохион байгуулж сонсох гэж байгаа юм.

Өөрөөр хэлбэл энэ хүний эрхийн асуудал дээр маш нухацтай хандана. Имэрч хандана.

Холбогдох хүний эрхийн асуудал ганцхан Хүний эрхийн Үндэсний Комиссын ажил биш ээ.

Хүний эрхтэй бүх л тулж байгаа Засгийн газрын болон бусад иргэний нийгмийн олон талын оролцоог хангаж байж энэ асуудлыг нэгдүгээрт ярих ёстой гэж үзсэн.

Нөгөө талаараа энэ эрхийг нэлээн нарийвчилж, задалж, эрх тус болгоноор нь тайланг сонсож, гишүүд асуулт хариулт хэлбэрээр явья гэсэн ийм санаачилгыг Байнгын хороон даргын хувьд гаргаж ярьж байгаа.

Тэр утгаараа оролцож байгаа албан тушаалтнуудыг Та бүхэнд эхлээд танилцуулъя.

Ж.Хунан Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга, Д.Сүнжид Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн, Х.Мөнхзул Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн, Н.Баасанжав Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн, С.Зулпхар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд, Ц.Адъяахишиг Хүний эрхийн Үндэсний Комиссын Тамгын газрын дарга, Д.Баяндүүрэн Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн, Ажлын албаны дарга, Г.Билгүүн Төрийн албаны зөвлөлийн ажлын албаны дарга, Б.Баярхүү Улсын Ерөнхий прокурорын газрын Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн ахлах прокурор, хууль цаазын шадар зөвлөх, Х.Цэцгээ Хүний эрхийн Үндэсний Комиссын Хүний эрхийн сургалт, сурталчилгааны хэлтсийн дарга, Д.Ёндонжамц Хүний эрхийн Үндэсний Комиссын Судалгаа, дүн шинжилгээ, хяналт шалгалтын хэлтсийн дарга, Г.Ууганбаатар Хүний эрхийн Үндэсний Комиссын Гомдол мэдээлэл шалгах хэлтсийн дарга, Д.Баярболд Нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга, М.Оюунчимэг Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламж үйлчилгээний газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, П.Бат-Эрдэнэ Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Зарлагын хэлтсийн дарга, М.Цогтбаатар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын хэлтсийн дарга, Д.Ганболд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүн амын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын хэлтсийн дарга, Б.Алтантулга Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын

хэрэгжилтийг зохицуулах газрын хэлтсийн дарга.

Нэр уншиж байхад албан тушаалтнууд босоод байгаарай. Гишүүд дараа нь нэр цохож асуулт асууж болно.

Т.Ням-Очир Боловсролын ерөнхий газрын дарга, Д.Мөнгөнжин Хил хамгаалах ерөнхий газрын Захиргааны удирдлага эрхэлсэн дэд дарга, бригадын генерал, Ж.Өсөхбаяр Зэвсэгт хүчний жанжин штабын нэгдүгээр орлогч дарга, хурандаа, Б.Даваа Шүүх шинжилгээний ерөнхий газрын Тэргүүн дэд дарга, цагдаагийн хурандаа, Д.Намсрай Онцгой байдлын ерөнхий газрын дэд дарга, Б.Дашдаваа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Захиргаа удирдлагын газрын дарга, хурандаа, Э.Бадамсамбуу Хууль тогтоомж, дотоод ажлын хэлтсийн дарга, дэд хурандаа, Ч.Цэнгэлбаяр Нийгмийн сэтгэл зүйн хэлтсийн дарга, хурандаа, Х.Нямгэрэл Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны дарга, Б.Мөнхбаяр Нийслэлийн Нийгмийн халамжийн газрын дарга, Б.Батсуурь Мөрдөн байцаах албаны дарга, цагдаагийн хурандаа, И.Батчулуун Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа, П.Болормаа Цагдаагийн ерөнхий газрын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, цагдаагийн дэд хурандаа, Ө.Ган-Өлзий Нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга, В.Оюумаа Хууль зүйн туслалцааны төвийн захирал, Б.Одончимэг Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн хуульч, Б.Батсүх Нийгмийн даатгалын Ерөнхий газрын Тамгын газрын дарга, Т.Энхбаяр Жендэрийн үндэсний хорооны нарийн бичгийн дарга бөгөөд ажлын албаны дарга, Ч.Ариунаа Хүний эрхийн

Үндэсний Комиссын Судалгаа, дүн шинжилгээ хариуцсан ахлах референт, Б.Оюуннасан Шүүхийн ерөнхий зөвлөлийн ахлах референт, Э.Ганцэцэг Шүүхийн ерөнхий зөвлөлийн референт, Ө.Гэрэлт-Од Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүн амын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн, Н.Адъяадорж Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн халамжийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн, Т.Мөнгөнцэцэг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын Хөдөлмөрийн харилцааны бодлогод зохицуулах газрын шинжээч, Д.Оюунгэрэл Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн, Д.Баялагцэнгэл Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн, Б.Ганзориг Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, Т.Ихтамир Нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөлийн дарга, Э.Алимаа Монголын хуульчдын холбооны судалгааны төвийн эрхлэгч, Ц.Отгонтунгалаг Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбооны Хөдөлмөр, нийгмийн бодлогын газрын дарга, М.Саранцацрал Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбооны Хүний эрх, хуулийн газрын хуульч гэсэн албан тушаалтнууд оролцож байна.

Мөн Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг дарга оролцож байна.

Одоо хамгийн эхний асуудал болох Хөдөлмөр эрхлэх эрхийн асуудлыг хэлэлцэнэ.

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэлийн Хөдөлмөрлөх эрхийн зарим асуудал сэдвийн талаар Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Дугарын

Сүнжид танилцуулна. 3 номерын микрофон.

Д.Сүнжид: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

22 дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлийн 3 дугаар бүлэг хөдөлмөрлөх эрхийн зарим асуудал сэдвийн хүрээнд байгаа.

Энэ сэдвийн хүрээнд төрийн үйлчилгээний албан хаагчийн хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилт, төрийн тусгай албан хаагчдын хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилт, Төрийн албаны тухай хуульд заасан төрийн албан хаагчийн эрх зүйн байдлыг товч дүгнэсэн. Тэгээд хоригдлын хөдөлмөрлөх эрхлэлт гээд ийм 3 үндсэн дэд сэдвийн хүрээнд авч үзэж байна.

Энэ бүлгийн хийсэн судалгаа гэвэл төрийн үйлчилгээний албан хаагчдын хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилт болон төрийн тусгай албан хаагчдын хөдөлмөр эрхийн хэрэгжилтийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр, Төрийн албаны зөвлөлийн хамтарсан Монгол Улсад мэргэжлийн иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь төслийн дэмжлэгтэйгээр гүйцэтгүүлсэн судалгаа байгаа.

Хоригдлын хөдөлмөрийн судалгааг олон улсын хөдөлмөрийн байгууллагын дэмжлэгтэйгээр гүйцэтгүүлсэн судалгаанд тулгуурлаж энэ бүлгийг боловсрууллаа.

Төрийн албан хаагчийн эрх зүйн өнөөдрийн байдал ямар байна вэ гэхээр 1992 оны Үндсэн хуульд суурилоод 1994 он, 2002 он, 2008 он, 2017 онд тус тус Төрийн албаны тухай хуулийг шинээр баталсан буюу шинэчлэн найруулжээ.

2017 онд батлаад 2019 оноос хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн Төрийн албаны тухай хууль дээр баталснаас хойш нийтдээ 17 удаагийн нэмэлт, өөрчлөлтийг 4 жилийн хугацаанд оруулсан байна.

Эндээс заалтаар нь үзэхээр 23 заалтад нэмэлт ороод 64 заалтад өөрчлөлт, 3 заалтыг хүчингүй болгосон ийм дүр зурагтай байна.

Тэгээд энэ нөхцөл байдлуудыг үзэхээр төрийн албанд улс төрийнхөөс бусад албан тушаалын орон тоо бүрэн нөхөгдөхгүй байна. Хүний нөөц дутагдалтай байна гэдэг ийм дүн тоо мэдээллийг Төрийн албаны зөвлөлийн статистикаас гарч байгаа юм. Ийм учраас энэхүү нөхөгдөхгүй байгаа орон тоог нөхөх зорилгоор. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, улс төрөөс хараат бус ангид байх Үндсэн хуулийн үзэл баримтлалд суурилсан Төрийн албаны тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор сонгон шалгаруулалтыг явуулах, шалгалтыг зохион байгуулах, хоёр албан тушаалын хооронд дүйцүүлэх, шилжих гээд энэ зохион байгуулалтыг оруулахаар нэмэлт, өөрчлөлтүүдийг тус бүр оруулжээ.

Эндээс үзэхэд энэ бүлгийн хүрээнд анхны Төрийн албаны тухай хуулийн үзэл баримтлалаасаа ухарсан зөрчилтэй ийм зохицуулалт байна гэж дүгнэж байгаа. Жишээлэх юм бол, улс төрийн албан тушаалд ажилласан албан хаагчийг төрийн захиргааны албанд дүйцүүлэх журмын асуудал байна.

Энэ дээр 2 асуудал гарч ирж байна.

Нэгдүгээрт, бүх улс төрийн албан тушаалд ажиллаж байсан албан хаагчдыг

төрийн захиргааны алба тушаалд дүйцүүлэхээр зохицуулж байгаа нь анхны “мерит” буюу “чадахуйн” зарчимд суурилсан Төрийн албаны тухай хуулийн үзэл баримтлалтай нийцэж байна уу гэдэг асуудал дээр эргэж харах ёстой. Энэ эргэлзээтэй болжээ гэдэг дүгнэлтийг хийж байна.

Хоёр дахь асуудал, төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгаа хангалтгүй байна.

Энэ дээр төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгааг хангана гээд Төрийн албаны тухай хууль дээр заасан.

Улсын Их Хурлаас Засгийн газраас 20 гаруй тогтоолоор салбарын цалин хөлс болон нэмэгдлын асуудлыг зохицуулж байгаа боловч адил ажил хийж байгаа ижилтгэх албан тушаал гүйцэтгэж байгаа тохиолдолд адил цалин хөлс олгоно гэдэг энэ зарчим хэрэгжихгүй байна.

Хамгийн сүүлд ялангуяа Засгийн газрын 2022 оны 488 дугаар тогтоол дээр орсон нэмэлтүүд нь харилцан адилгүй болсон бөгөөд хамгийн бага төрийн үйлчилгээний албан хаагч 8.6 хувиар нэмэгдсэн байна лээ.

Тэгээд 489 дүгээр тогтоолын хавсралтын дагуу орон нутгийн нэмэгдлийг олгох болсон. Үүнтэй холбоотойгоор орон нутагт ажиллаж байгаа албан хаагчдын хувьд цалингийн зөрүүтэй байдлууд үүссэн.

Босоо тогтолцоотой гэж ярьдаг шууд удирдлагаар хангах учиртай байгууллагуудын хувьд цалингийн нэмэгдэл байхгүй байна. Харин орон нутгийн агентлагуудын хувьд 20-иос 80 хүртэл хувийн цалингийн нэмэгдэл

нэмэгдсэн учраас энэ тогтоолын дагуу энд ажиллаж байгаа албан хаагчдын хооронд шилжилт хөдөлгөөн эрс ихэсжээ.

Энэ төрийн албан хаагчийн цалин хөлсний нэгдмэл байдал алдагдсантай холбоотой төрийн тусгай албан хаагчдын хувьд ялгаагүй яригдана.

Цэргийн байгууллагуудын хувьд цалинг харьцуулах юм цагдаагийн байгууллага, дотоодын цэргийн байгууллагатай харьцуулахад цэргийн байгууллагуудын цалин хөлс нь харьцангуй доогуур. Хамгийн доогуур байгаа нь Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны албан хаагчдын цалин хөлс харьцуулахад 400-аад мянгаар дунджаар нь авч үзэхэд ийм доогуур байдалтай байна.

Төрийн тусгай дотроо ийм.

Төрийн захиргаа дотроо сая орон нутгийн нэмэгдэлтэй холбоотой ялгаанууд гарч ирж байгаа юм. Тэгээд 2022 оны Засгийн газрын тогтоолоор нэмэгдэл тогтоохдоо 5 дугаар шатлалд ажиллаж байсан албан хаагчдын цалинг нэмээгүй. Энэ нь бусад 1-ээс 4 дэх шатлалыг байхгүй болгоод 1-ээс 4 дэх шатлалд ажиллаж байсан албан хаагчдын цалинг тодорхой хувиар нэмсэн боловч 5 дугаар шатлалд ажиллаж байсан албан хаагчдыг нэмээгүй байгаа нь бас тэдний цалин хөлсний зөрүү, хийж байгаа ажилдаа тохирохгүй байна гээд энэ үзүүлэлтийг харуулж байна.

Төрийн үйлчилгээний албан хаагчдын тухайд нийтдээ 2100 орчим төрийн үйлчилгээний албан хаагчдыг хамруулсан судалгаа хийсэн.

Ингээд аваад үзэхээр соёлын салбар, боловсролын салбар, эрүүл мэндийн салбар, шинжлэх ухааны салбар, бусад салбар гээд энэ салбарт ажиллаж байгаа хүмүүсийн судалгаанд хамрагчдын хувьд 72.5 хувь нь зөвхөн цалингийн орлогоороо амьдардаг гэдгээ хэлж байгаа бөгөөд эдийн засгийн хувьд гачигдалтай. Өдөр тутмынхаа хэрэглээг хангах хэмжээнд амьдарч байна гэдэг ийм хариултыг өгч байгаа.

Тэгээд амьжиргааны чанартаа хамгийн сэтгэл хангалуун биш байгаа, хамгийн цалингийн баталгаа муу байгаа гэж үзэж байгаа хэсэг энэ байна.

Төрийн үйлчилгээний албан хаагчдын онцлог нь өөрөө энд 68.6 хувь нь эмэгтэйчүүд ажилладаг. Төрийн нийт албан хаагч дундаа хамгийн их тоог эзэлдэг ийм алба байна.

Тэгээд төрийн үйлчилгээний албан дээр анхаарах ёстой асуудлууд юу вэ гэхээр боловсролын салбар.

Нэгдүгээрт, удирдлагуудыг улс төрөөс хамааралтайгаар сургуулийн болон цэцэрлэгийн захирлуудыг сольж байгаа асуудлыг болиулах хэрэгтэй байна. Энэ тогтворгүй байдал чинь бусад албан тушаалын үйл ажиллагаагаа хэвийн, чиг үүргээ хэвийн гүйцэтгэхэд нөлөөлж байна гэдэг асуудлыг ярьж байгаа.

Хоёрдугаарт, ялгаварлан гадуурхалт ярьж байгаа.

Гуравт нь, цалин хөлсний асуудлыг дурджээ.

Эрүүл мэндийн салбарт ажиллаж байгаа ажилтны хувьд цалин хөлс, нийгмийн бодлогын дурдахын сацуу энд ахиад нэгдэж байгаа нэг асуудал нь

аюулгүй байдлыг хангуулах шаардлага байна гэдгээ хэлж байгаа.

Өөрөөр хэлбэл эрүүл мэндийн ажилтан, эмч, эмнэлгийн ажилтны 3 хүн тутмын нэг нь ямар нэг байдлаар үйлчлүүлэгчээс бид халдлагад өртөж байна. Доромжлол, заналхийлэл. Заримдаа эрүүл мэндэд халдах үзэгдэл гардаг. Ийм нөхцөлд өртөж байна гэдгээ хэлдэг.

Соёлын салбарын цалин хөлсний асуудал ярихын зэрэгцээ ажлын байрны дарамтын асуудлыг ярьж байна.

Бусад төрийн туслах үйлчилгээний албан хаагчдад нэмэгдэл цалин хөлс, урамшуулал олдохгүй байна.

Дээрээс нь ажлын байрны тодорхойлолтод зааснаас гадна нэмэлт ажил үүрэг гүйцэтгүүлж байна гэдэг асуудлыг хөндсөн байна.

Ингээд төрийн үйлчилгээний албан хаагчдын хувьд эдгээр асуудлуудыг хөндсөн бол төрийн тусгай албан хаагчийн хөдөлмөрлөх эрхээс бид сүүлийн 3 жилийн хугацаанд хууль тогтоомжид нь нэмэлт, өөрчлөлт орсон, эсвэл цалин хөлс нь харьцангуй дээгүүр тогтоосон салбаруудыг орхиод 6 байгууллагыг сонгож авсан.

Энэ дээр Зэвсэгт хүчний жанжин штаб, Онцгой байдлын ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Шүүхийн шинжилгээний ерөнхий газар гээд ийм байгууллагуудыг сонгож авсан.

Эндээс үзэхээр тус тусынхаа хуулиар зохицуулж байгаа учраас цалин хөлс нь ялгаатай байдал нь хэвээрээ үргэлжилж байна.

Хоёрдугаарт, нь хэлэх ёстой зүйл бол санхүүжилтийг нь бүрэн олгох тухай асуудал заавал яригдах гэж байна.

Дүрэмт хувцас, хоол, норматив, хүнс гээд үүний санхүүжилтийг өгсөн хэмжээнээс тухайлах юм бол 2023 онд Зэвсэгт хүчний жанжин штабт гэхэд хүссэнийх нь 20 хувийг нь олгосон байна. Хүссэн санхүүжилтийнх нь.

Тэгэхээр энэ санхүүжилтийн асуудлыг тооцооллын үндсэн дээр бүрэн олгох тухай асуудлыг дурдах ёстой болж байна.

Энэ хэлээд байгаа шилжилт хөдөлгөөн, цалин хөлсний ялгаатай, зөрүүтэй байдал ямар үр дагавар үүсгэж байна вэ гэвэл төрийн үйлчилгээний албан хаагчаас жилийн хугацаанд 10 мянган хүн өөрийнхөө хүсэлтээр 2021 онд чөлөөлөгдөж байсан бол 2022 онд энэ нь 13 мянга гэж өссөн байна.

Нийт тоогоороо энэ албанаас өөрийнхөө хүсэлтээр гарч байгаа албан хаагчдын тоо эрс өссөн. Нэмэх нь дотоодын шилжилт хөдөлгөөн буюу арай өндөр цалинтай алба руу шилжих, хүсэлтээрээ шилжих хөдөлгөөн одоо ч гэсэн явагдсаар байна.

Тэгэхээр хүний нөөцийн дутагдлыг даван туулахдаа цалин хөлсний нэгдмэл байдлыг хангахгүй бол болохгүй гэдэг дүгнэлтийг хийсэн.

Энэ төрийн тусгай албан хаагчдын хувьд онцгой нөхцөлийн нэмэгдэл харилцан адилгүй тогтоож байна. Хамгийн өндөр нь 30, хамгийн бага нь 5 хувь байна. Үүнийг Засгийн газрын тогтоолоор тогтоож байгаа юм байна. Үүнийг нэгтгээд адилхан 30 хувьд хүргэх

нь зүйтэй юм гэдэг ийм саналыг өгч байгаа.

Хоригдлын хөдөлмөр эрхлэлтийн тухайд олон улсын хөдөлмөрийн байгууллага 29, 105 дугаар конвенцод нийцэж байгаа байдлыг 2016 онд Хүний эрхийн Үндэсний Комиссоос судалж байсан. Тэр үед гаргасан дүгнэлтийн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлжээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 2017 оны шинэчилсэн найруулгад хууль тогтоомжийн хувьд залруулсан байна.

11 хорих ангид хийсэн судалгаагаар хөдөлмөр эрхлэлтийн асуудал дээр сайн дураараа, төрийн хяналт доор гэрээ байгуулсны үндсэн дээр өөрөөс нь зөвшөөрөл авч хийж байна. Аж ахуйн нэгж дээр хараа хяналтгүйгээр өгөхгүй байна гэдэг энэ конвенцоос заасан нөхцөлүүдийг үндсэндээ хангаж байна.

Цалингийн хэмжээ цалингийн доод хэмжээнээс багасгахгүй хэмжээнд байгаа боловч цаашид анхаарах ёстой асуудлууд нь хаалттай хорих ангид дотооддоо гаргаж болохгүй учраас нөгөө хаалттай орох ангийн дотоод бүсдээ ажлын байр бий болгох тухай асуудал дээр анхаарал хандуулах. Энэ дээр зөвхөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага төдийгүй нутгийн удирдлагын байгууллага, бусад салбарын байгууллагуудтай уялдаа холбоотой ажиллах нь зүйтэй байна гэдэг ийм дүгнэлтийг хийж байгаа.

Бүх насаараа хорих ялаар шийтгүүлсэн ангид ажил хийхгүй. Үүнийг хуулиар хориглоогүй боловч зохион байгуулалтын хувьд энэ ажил хөдөлмөр хийлгэх талаар анхаарах нь зүйтэй байна гэдэг саналыг өгч байгаа.

Сургалт хүмүүжлийн тусгай ангид мэргэжлийн хэрвээ насанд хүрсэн байх юм бол тэр хүүхдүүдийн хувьд насыг нь харгалзаад, онцлогийг нь харгалзаад мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн тусгай мэргэшүүлэх сургалтад хамруулах талаар анхаарах нь зүйтэй байна гэдэг саналыг өгч байгаа.

Ингээд энэ бүлгийн хүрээнд нийтдээ төрийн үйлчилгээний болон төрийн тусгай албан хаагчтай холбоотой 5 саналыг өгч байна.

Нэгдүгээрт нь, төрийн албаныхаа үзэл баримтлалыг тодорхой болгоё. Цаашид хүний нөөцийн хомсдол, дутагдлыг хэрхэн яаж даван туулах вэ. Үнэхээр чадахуйн зарчимд суурилсан гэдэг энэ үзэл баримтлалаа хэвээрээ байх уу, эсвэл өөрчлөх үү гэдэгтэй холбоотой шинээр энэ асуудлыг авч үзэх тухай саналыг өгсөн.

Цалин хүнс болон нэмэгдэл баталгааг нь нэгдмэл байдлаар авч үзэхгүй бол ингэж сугалсан байдлаар тодорхой зарим байгууллагуудад давуу тал олгох байдлаар, тодорхой салбарыг дэмжих байдлаар явах нь төрийн албан хаагчдын дунд тун сэтгэл хангалуун биш байдал үүсгэж байгаа бөгөөд аж амьжиргаанд нь шууд нөлөөлөхүйц үр дагавар үүсгэж байна.

Төрийн албаны тухай хууль нь 66.1.2-ын дагуу төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг бүхэлд нь ер нь ямар байгаа юм бэ гэдгийг салбараар нь, байгууллагуудаар нь дүгнэж үзээд эргээд хэрхэн яаж зохицуулах талаар дүгнээч гэдэг 3 дахь саналыг өгсөн.

Төрийн тусгай албан хаагчдын хувцас хэрэгсэл, хүнсний нормд

шаардагдах тооцооллын дагуу төсвийг бүрэн олгох хэрэгтэй байна.

Үндэслэлгүйгээр хасах тухай, хэмнэх тухай асуудлыг эргэж харж үзэх ёстой байна гэдэг саналыг өгч байгаа.

Төрийн албан хаагчийн эрх зүйн байдлыг баталгаажуулахын тулд зарим хуулиудад нэмэлт, өөрчлөлтийг оруулах ийм тодорхой саналуудыг илтгэлдээ тусгасан.

Хоригдлын хөдөлмөр эрхлэлтийн хувь дээр ажлын байрыг нэмэгдүүлэх, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх талаар салбар хоорондын уялдаа холбоог хангая гэдэг саналыг өгч байгаа.

Нэмээд хоригдлыг суллахад бэлтгэх хөтөлбөр байгаа боловч төлөвлөгөө байхгүй, санхүүжилт байхгүй байгаа учраас энэ хэрэгжилтийг хангах нь зүйтэй байна гэдэг энэ саналыг тус тус өгсөн.

Дэлгэрэнгүй асуух зүйл байвал нь хариулъя.

Ц.Сандаг-Очир: Хөдөлмөрлөх эрхийн зарим асуудал сэдвээр Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Д.Сүнжид гишүүний тайланг сонслоо.

Тайлантай холбогдуулаад асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү? Ш.Адьяа гишүүнээр тасаллаа. Г.Тэмүүлэн гишүүн асуултаа асууя.

Г.Тэмүүлэн: Хөдөлмөрлөх эрхтэй холбогдуулаад ганц нэг тодруулах асуудлууд байна.

Тайланг ерөнхийд нь уншаад танилцлаа. Тайлан дээр дурдагдсан нэг онцлох асуудал байна.

Энэ дотроо тэр дундаа боловсролын салбар дээр өнөөдөр Монгол Улсад 1700 орчим сургууль, цэцэрлэгүүд байгаа байх. Боловсролын салбар дээр өөрөө улс төржилтийн асуудал их байдаг.

Тэгэхээр өнөөдөр энэ эрх зүйн орчинтой холбогдуулаад 1700 гаруй боловсролын байгууллагын удирдлагуудыг халах солих асуудал тодорхой өнгөн төдий, улс төрчдийн намын үзэмжээр гэдэг юм уу тухайн тэр сум, дүүрэг, нийслэл дээрх улс төрийн албан тушаалтнуудын үзэмжээр шийдэгдэж байгаа асуудал байгаа.

Тэгэхээр би сүүлийн 2 жилийн статистикийг мэдэхгүй байна. Өнгөрсөн 2 жилийн хугацаанд анхан шатанд улс төрийн албан хаагч нарын томилгоогоор ажил, албан тушаалаасаа чөлөөлөгдсөн, хөдөлмөрлөх эрх нь зөрчигдсэн ийм хэчнээн тохиолдол байгаа юм бол.

Эргээгээд хуучин 2019 он хүртэлх статистикийн судалгаагаар оронд нь томилогдсон хүмүүсийн бараг 40 орчим хувь нь мэргэжлийн бус хүмүүс байсан. Энэ нь боловсролын салбарт огт ажиллаж байгаагүй, энэ салбарын дадлага туршлага байхгүй, хамт олон дундаасаа мерит зарчмаар гарч ирээгүй ийм эрүүл бус тогтолцоог бид хууль эрх зүйн орчныхоо хүрээнд бий болгоод байна гэж хараад байгаа юм.

Тэгэхээр энэ томилогдсон хүмүүсийн хэдэн хувь нь мэргэжлийн бус байна вэ? Мэргэжлийн бус хүмүүс тэр салбар дээр очиж тэр салбарыг самрах, тэр салбар дээр мэргэжлийн бус шийдвэр гаргах, улс төрийн өнгө аясаар хандах энэ асуудал дээр та хэд судалж үзсэн үү?

Тэгэхээр бид нарын хувьд энэ гажуудлыг нэг талдаа засах ёстой. Хууль

эрх зүйн орчин дээр нь өөрчлөлт оруулах ёстой. Энэ боловсролын салбарт байгаа ажлын байрны дарамт болоод энэ тогтворгүй байдлыг өөрчлөх ёстой гэж харж байгаа.

Анхан шатанд очиход багш, албан хаагч нарын нийтлэг эрх зөрчигдөж байгаа. Хөндөж байгаа асуудлууд ерөнхийдөө энд байна гэж харж байгаа.

Тэгэхээр би тоон судалгаагаар улсын хэмжээнд бүх сум, дүүрэг, аймаг, нийслэлийн хэмжээнд хэчнээн хүмүүс ер нь ингэж эрх нь зөрчигдөөд байгаа юм бэ гэдэг асуудал байгаа.

Эдгээр зөрчигдсөн хүмүүсээс хэд нь хөдөлмөрийн маргаан үүсгэж шүүхэд шилжиж, шүүхэд гомдол, хүсэлт гаргаж явж байгаа юм бэ гэдэг асуудал байгаа юм.

Тэгэхээр Та бүхэн магадгүй тоон судалгаа, дүнгүүд нь байгаа байх. Энэ дүнгээр ийм байдал байхад, ийм тогтворгүй бүтэц байхад, ийм гажуудал байхад бид нэг талдаа сургууль, боловсролын салбарын амжилт, чанар, тэр сургалтын стандартыг ярих боломж бололцоо байхгүй болчихоод байгаа юм.

Тэгэхээр энэ дээр Та бүхэн ер нь яах ёстой гэж үзэж байгаа юм.

Ц.Сандаг-Очир: Болсон уу?

Г.Тэмүүлэн: Дээрээс нь орны хүмүүсийг томилж байгаа. Мэргэжлийн магадгүй захирал, эрхлэгч байсан хүмүүсийг чөлөөлж байгаа байх. Орны хүмүүсүүдийг томилохдоо үүрэг гүйцэтгэгчээ томилж байгаа тохиолдлууд хэр байгаа бол.

Төрийн албаны зөвлөл энэ дээр тооцоо судалгаа байгаа бол хариулаач гэх гээд байгаа юм.

Үндсэндээ бид мэргэжлийн хүмүүсийг нь л яг жинхэлж л томилдог байх ёстой болчихоод байгаа юм.

Тэгэхээр үндсэндээ сүүлийн хоёр, гурван жилийн хугацаанд дандаа үүрэг гүйцэтгэгчээр томилсон, мэргэжлийн бус хүмүүс томилсон, улс төрийн өнцгөөр томилогдсон ийм л асуудлууд байгаа.

Тэгэхээр энэ дээр Та бүхэн нэг тоон судалгаа мэдээлэл өгөөч.

Ц.Сандаг-Очир: Г.Тэмүүлэн гишүүний асуултад Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Д.Сүнжид.

Дараа нь, Төрийн албаны зөвлөлийн ажлын албаны дарга Г.Билгүүн, Боловсролын ерөнхий газрын дарга Т.Ням-Очир дарга нар нэмэлт тайлбар өгч болно.

Д.Сүнжид гишүүн. Ажлын хэсгийн 3 дахь микрофон өгье.

Д.Сүнжид: Хүний эрхийн Үндэсний Комисс жил болгон ирүүлж байгаа хамгийн их ирүүлдэг гомдлын нэг нь хөдөлмөрлөх эрхийн зөрчил.

Энэ дотроос цалин хөлс авахгүй байна. Ажил амралтын цаг зөрчлөө. Хууль бус ажил хийхийг даалгалаа гэхээс гадна ажлаас үндэслэлгүй халлаа, дарамт учрууллаа гэдэг гомдол 30 хувийг нь эзлээд байгаа юм.

2022 оны хувьд 246 гомдол ирсэн. Үүнээс яг төрийн албан хаагчтай холбоотой гээд түүхээрээ 82 гомдол болж байна. Төрийн үйлчилгээний албан хаагч

гэж түүгээгүй. Нийт төрийн албан хаагч гэдгээр нь түүсэн.

Тэгэхээр манайх хэрэвзээ үндэслэлгүй халагдсан гэж үзвэл шүүх рүү хандах учраас халагдахаас өмнө сахилгын шийтгэл үндэслэлгүй ноогдууллаа, ажлын байрны дарамт ялгаварлан, гадуурхалт байна гэж үзсэн тохиолдолд манай дээр 82 гомдол ирсэн байна.

Төрийн албаны зөвлөлөөс өөрсдийн мэдээ тайлангаа танилцуулна. Танилцуулчих учраас давтаж ярихгүйгээр орхиё.

Энэ төрийн үйлчилгээний албан хаагчдын хувьд шүүхэд хандаж байгаа байдлыг аваад үзэхээр 2022 онд 1169 иргэн тухайн ажлаасаа үндэслэлгүй халагдсан гэдгээрээ үүнийг нэхэмжлэл үүсээд тэгээд үүний 30 хувь нь шийдэгдсэн ийм статистик байна.

Бид сая дурдаад байгаа 2100 төрийн үйлчилгээний албан хаагчдын дунд хөдөлмөр эрхлэлтийн ямар зөрчил хамгийн их өөрөө өртөж байна вэ гэж асуухаар илүү цагийн хөлсөө авч чадахгүй байна гэдгээ хамгийн түрүүн хэлдэг юм билээ.

Тэгээд түүнээс гадна үндэслэлгүйгээр ажил даалгах, ялгаварлан гадуурхах гэдэг юм уу тодорхой намын юм уу, эсвэл бүлгийн шинж чанартайгаар ялгаварлаж байна гэдэг асуудлыг ярьдаг.

Эндээс үзээд ингээд 5 албан хаагч тутмын 1 нь миний эрх зөрчигдөж байна гэж хэлээд байгаа мөртлөө Г.Тэмүүлэн гишүүнээс сая яг асуугаад байгаа хэд нь гомдол гаргаж байна вэ гэхээр энэ ерөөсөө 11 хувь л гээд байгаа юм.

Тэгэхээр энэ дээр хэдийгээр өөрөө эрх нь зөрчигдөж байна гэж бодож байгаа боловч албан ёсоор холбогдох байгууллагад хандаж байгаа хувь бага юм билээ.

Тэгээд үүнээс байгууллагад хэрвээ хандчихсан бол журмынхаа дагуу шийдвэрлээд явж байгаа ийм л дүр зурагтай байна.

Ц.Сандаг-Очир: Боловсролын ерөнхий газрын дарга Т.Ням-Очир нэмж тайлбар хариулт өгье. Наад 7 дугаар микрофон. 7 дугаар микрофоныг өгье.

Т.Ням-Очир: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Тэгэхээр Боловсролын ерөнхий газраас жил болгон эхний жилдээ ажиллаж байгаа удирдах ажилтны сургалтуудыг хийдэг.

Тэгэхээр 2022 онд эхний жилдээ ажиллаж байгаа цэцэрлэгийн эрхлэгч, сургуулийн захирлын сургалтад 459 хүн хамрагдсан байна. 2023 оны сургалтыг бид дөнгөж сая 4 дүгээр сард хийгээд дууслаа. Энд 100 захирал, 109 эрхлэгч хамрагдсан байна.

Тэгэхээр эхний жилдээ ажиллаж байна гэдэг маань энэ хүмүүс томилогдоод эхний жилийн сургалтад хамрагдаж байгаа гэсэн агуулга байгаа учраас ийм хэмжээгээр чөлөөлөгдөөд шинэ хүмүүс томилогдож байна гэж ингэж харж болно.

Ер нь яах вэ 2012-2017 оны судалгааг аваад үзэхээр зөвхөн ерөнхий боловсролын сургуулийн захирал гээд 769 захирал солигдсон статистик тоо өмнөх тоонууд дээр байдаг.

Сая Засгийн газрын “Таван Ш” ажиллагааны хүрээнд “Шүүр” ажиллагааны ажлын хэсэг байгуулагдаж ажилласан.

Яг энэ судалгаагаар 82 цэцэрлэгийн эрхлэгч, 98 сургуулийн захирал түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байгаа. Өөрөөр хэлбэл жинхлэн томилогдоогүй байгаа гэсэн ийм судалгааны үр дүнгүүд гарсан байдаг.

Ер нь шинээр томилогдож байгаа нийт хүмүүсийг харахаар 30 гаруй хувь нь 5 хүртэлх жил ажиллаагүй буюу ажлын туршлагын шаардлага хангахгүй. Дахиад энэ дотроо аваад үзэхээр 15 хувь нь ямар нэг байдлаар боловсролын салбарт ажилласан туршлага байхгүй, ажиллаж байгаагүй гэсэн ийм дүн мэдээнүүд бид нарын энэ сүүлийн үед гарсан авсан судалгаануудаар гардаг.

Ийм учраас Улсын Их Хуралд өргөн барьчихсан байгаа Боловсролын ерөнхий хуульд цэцэрлэг, сургуулийн удирдлагаар ажиллах албан хаагчид тавигдах шаардлагыг тусгайлан оруулж өгч байгаа зүйлүүд байгаа.

Ц.Сандаг-Очир: Төрийн албаны зөвлөлөөс 4 номерын микрофон өгье.

Г.Билгүүн: Төрийн албаны зөвлөлийн ажлын албаны дарга Г.Билгүүн. Г.Тэмүүлэн гишүүний асуултад хариулья.

Төрийн албаны зөвлөл дээр ерөнхий тоо мэдээ нэгтгэгдээд гарч байгаа. Яг 2022 оны тухайд төлөвлөгөөт хяналт шалгалтын хүрээнд 33 байгууллагын 791 албан хаагч, бусдаас ирүүлсэн гомдол, мэдээллийн дагуу 25 байгууллагын 221 буюу нийтдээ 58 байгууллагын 1012 албан хаагчид

холбогдох томилгоотой холбоотой хяналт шалгалтыг хийсэн байгаа.

Үүнээс 193 иргэнийг төрийн албанд Төрийн албаны тухай хууль тогтоомж зөрчиж томилсныг Төрийн албаны зөвлөлийн шийдвэрээр тогтоосон.

Үүнтэй холбогдуулж Төрийн албаны зөвлөлөөс 30 тогтоол гаргасан. Нэг ёсондоо энэ хүмүүсийг Төрийн албаны тухай хууль тогтоомж зөрчиж томилсон байна.

Тийм учраас зөрчлийг арилгах хугацаатай үүрэг даалгавар өгсөн 30 тогтоол гаргасан. 25 тогтоол бүрэн биелсэн байна. 18 иргэнд холбогдох 5 тогтоолын хэрэгжих хугацаа одоогоор болоогүй байгаа.

Төрийн албан хаагчийн хөдөлмөрлөх эрх зөрчигдсөнтэй холбоотой гомдол ирснээс 63 гомдолд маргаан үүсгэж шалгасан байна.

Энэ нь 2021 оныхтой харьцуулахад 27-оор буурсан байгаа.

Энэ 63 маргаантай захиргааны актыг агуулгаар нь авч үзэх юм бол 16 нь сахилгын шийтгэл ногдуулсантай холбоотой, 17 нь төрийн албанаас чөлөөлсөнтэй холбоотой, 4 нь төрийн албанаас халсантай холбоотой, 7 нь албан тушаал бууруулсантай холбоотой, 14 нь төрийн жинхэнэ албан хаагчийн нийгмийн баталгаатай холбоотой, 2 нь төрийн албанд сонгон шалгаруулж томилсонтой холбоотой, 3 нь төрийн албаны ерөнхий.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Б.Дэлгэрсайхан гишүүн асуултаа асууя.

Б.Дэлгэрсайхан: Би гурван асуулт тавья гэж бодож байгаа юм.

Төрийн албаны зөвлөлийн ажлын албаны дарга Г.Билгүүн орж ирсэн юм байна.

Энэ хөдөө орон нутагт ажиллах боловсон хүчин бараг олдохгүй болсон. Та нар мэдэж байгаа байх. Тэгээд би өмнө нь ч гэсэн чуулган дээр хэлж байсан.

Та нар тэр ч тэнцэхгүй гээд энэ “Шүүр” ажиллагаагаар тэр үүрэг гүйцэтгэж байна, тэр шалгалт өгөөгүй гээд баахан хүнийг халж солих юм. Одоо тийм юм хөдөө орон нутаг, засаг захиргаанд очсон байна л даа.

Тэгээд халчхаж болно. Хэн ажиллах юм бэ? Тэр шалгалтыг нь жоохон юу гэдэг юм. Ер нь хөдөө орон нутагт бас ярьж ярьж байгаад нэг боломжийн хүнээ л тавьж байгаа шүү дээ. Яг ний нуугүй хэлэхэд.

Үүнийг Төрийн албаны зөвлөл шалгалт нэрээр. Өөрсдөө яг амьдрал дээр нь очиж ажиллаж үзээгүй. Энэ шалгалтыг нь жоохон ялгамжтай ханддаг юм уу, орон нутгийн онцлогийг нь харгалздаг юм уу. Та нар үүнийгээ эргэж харахгүй бол.

Уг нь энэ “Шүүр” ажиллагаагаа Улаанбаатар, энэ төвлөрсөн газраар л хийх ёстой юм уу гэж би ойлгоод байгаа юм. Түүнээс биш тэр хөдөө орон нутагт байгаа нэг цэцэрлэгийн эрхлэх, сургуулийн захирал гээд жижиг сум, орон нутгийн юмаар “Шүүр” ажиллагаа хийгээд юу шалих вэ дээ. Эзнээ олмоор байгаа юм. Үүнд нэг хариулт өгөөч. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, Хөдөлмөр хамгааллын дэд сайдаас асууя. Орж ирсэн нь дээр нь

Одоо ингээд зуны улирал эхэлсэн. Ер нь компаниуд хөдөлгөөнд ороод ажил амьдрал өрнөж байна. Ажиллах хүчин олдохоо байсан. Тэгээд гаднаас ажиллах хүчин оруулж ирдэг, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр нугалсантай тэнцүү авдаг татвараас барилга болоод зам, үйлдвэр барьж байгаа компаниудыг чөлөөлж болдоггүй юм уу?

Бид чинь үндсэндээ ажлыг хүнгүй байна шүү дээ. Ялангуяа хүнд ажлыг хийх хүн тун хомс байгаа. Энд хариулж өгөөч.

Хоёр дахь асуудал. Хөдөлмөр хамгааллын дэд сайдаас нэмж асуух юм байна. Өнгөрсөн жил Хөдөлмөрийн хуулийг бид шинээр баталсан л даа. Уржнан жил ч билүү. Биш ээ, түрүүчийн парламентаар Ц.Мөнх-Оргил гишүүн өргөн бариад. Тийм.

Ингэж батлахдаа бид уул уурхайн компаниуд дээр 14, 14 хоногийн ээлжтэй ингээд хийчихсэн юм. Үүнээс болоод ямар юм бий болж байна вэ гэхээр үндсэндээ хөдөлмөрлөх тэр хоног өдөр нь замынхаа хоногтой нийлээд яг ажил хийх хугацаа 12 хоног. Заримдаа ч хол газар машин тэргээр явсаар байгаад 11 хоног л ажиллаж байгаа юм.

Энэ 20, 10-ын ээлжтэй байсныг 14, 14 хоног болгосноос болоод уул уурхайн салбарт үндсэндээ 56 мянган ажилтан дутчихсан. Энэ 56 мянган ажилтныг нөхөж бий болгоно гэдэг бараг боломжгүй зүйл.

Тэгээд 14, 14 хоногоос болоод цалин хөлс нь буурсан. Үүнтэй холбогдуулаад аягүй их гомдолтой байдаг.

Тэгээд энэ талаар Хөдөлмөр хамгааллын яам ер нь юу гэж боддог юм? Үүнийг өөрчлөх асуудал дээр.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Төрийн албаны зөвлөлийн ажлын албаны дарга Г.Билгүүн хариулъя. 4 дүгээр микрофон.

Г.Билгүүн: Б.Дэлгэрсайхан гишүүний асуултад хариулъя.

Орон нутагт ажиллах хүч олдохгүй байгаа гэдгийг маш сайн ойлгож байгаа. Монгол Улсын 330 сумаас 312 суманд төрийн албан хаагчид нь орон тоо дутуу ажиллаж байгаа. Үүнийг бид бүгд маш сайн ойлгож байгаа.

Төрийн албаны зөвлөлийн зүгээс шалгалтыг арай уян хатан болгох, тухайн ажил мэргэжлийн онцлогт нь тохирсон шалгалт авдаг болох энэ чиглэлээр ажиллаж байгаа.

Нэг юмыг онцолж хэлэхэд таны дурддаг “Шүүр” ажиллагааг Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас хэрэгжүүлж байгаа.

Энэ дээр Төрийн албаны зөвлөл ямар чиглэлээр яаж хамтарч ажиллах вэ гэдгээ Засгийн газрын Хэрэг эрхлэх газартай ярилцаад явж байгаа.

Орон нутагт ажиллах хүч олдохгүй байна гэдэг дээр бид судалгаа хийж үзсэн. Тодорхой тооны хэдэн мэргэжил дээр дутуу байгаа юм билээ. Голцуу тархвар зүйч, малын эмч, зоотехникч гэсэн мэргэжлүүд.

Энэ үндсэн хэд хэдэн шалтгаантай. Тухайн үеийн онцлогоосоо шалтгаалаад салбарынхаа хууль тогтоомжийг харилцан адилгүй

баталчихдаг. Одоо орон нутагт суман дээр жишээлээд ярих юм бол малын эмч нь төрийн захиргааны албан хаагч, ТЗ-ийн албан тушаалтан, хүний эмч нь ТҮ-гийнх. Энэ асуудал нэлээн хэдэн жилийн өмнө яагаад болсон бэ гэхээр малын эмчээр ажиллах хүн олдохгүй байна, цалин нь бага байна, ТҮ-гийн цалин бага байна гэж байгаад тухайн үеийн Засгийн газрын шийдвэрээр малын эмчээ төрийн захиргааных болгочихсон.

Тэгэхээр нөгөөдөх нь Төрийн албаны тухай хуулиараа шалгалт өгөхөөс өөр замгүй болгочихсон.

Байгаль хамгаалагч нарын цалингаа нэмэгдүүлнэ гээд ТҮ-гийн албан тушаалд мөрөөрөө ажиллаж байсан хүмүүсийг төрийн захиргааны албан хаагч болгочихсон.

Тэгэхээр нөгөө хүмүүс нь аргагүйн эрхэнд Төрийн албаны тухай хууль тогтоомжоороо нэгэнт хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжоороо шалгалт өгөхөөс өөр аргагүй болчихсон.

Тэгэхээр энэ бол төрийн албаны албан хаагчийн ангилал, зэрэглэл, цалин хөлсний ялгамжтай байдал, шатлал энэ ерөөсөө тодорхой хэмжээгээр алдагдсан учраас төрийн албаны орон тоо нөхөгдөхгүй байгаагийн нэг том шалтгаан энэ байгаа юм.

Тийм учраас энэ дээр бид Засгийн газар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Сангийн яамтай яриад энэ сарын эхээр Төрийн албаны зөвлөлийн өнгөрсөн оны тайланг Их Хурлын нэгдсэн чуулганаар хэлэлцүүлэх үеэр ч гэсэн бид бүгд хэлсэн.

Яг энэ асуудлыг төрийн төрийн албан хаагчийн цалин хөлс, ангилал

зэрэглэл, цалингийн шатлал, тэгээд дээрээс нь нийгмийн баталгаа. Энэ асуудлыг салбар харгалзахгүйгээр улсын хэмжээнд нэг жигд болгох арга хэмжээ авахаас нааш энэ асуудал нэг мөр цэгцрэхгүй. Энэ дээр Их Хурал, Засгийн газар, бүх яамд бүгдээрээ хамтарч ажиллахгүй бол яг нэгдсэн нэг бодлого гэдэг юм нь алдагдчихсан.

Тийм учраас зарим салбарт нь боловсон хүчин харьцангуй гайгүй олоод, заримд нь олдохгүй байгаа ийм л асуудал үүсчихсэн байгаа. Бодит байдал дээр.

Төрийн албаны зүгээс наад зах нь хүний нөөцөөр хангахын тулд ажилласан жилийн тодорхой хугацаагаар бууруулах, тавигдаж байгаа шаардлагыг нь харьцангуй уян хатан болгох, шалгалтынхаа агуулахыг шинэчлэх.

Тохирсон шат шатад нь өөр түвшний шалгалт авах чиглэлээр өөрийнхөө эрх хэмжээний хүрээнд дүрэм журам энэ тэрээ шинэчлээд явж байгаа гэдгийг хэлье.

Энэ талаар дэлгэрэнгүй мэдээлэл шаардлагатай гэвэл танд танилцуулга хэлбэрээр бичгээр хүргүүлье.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд С.Зулпхар. 5 номерын микрофон.

С.Зулпхар: Байнгын хорооны дарга, гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Улсын Их Хурлын гишүүн Б.Дэлгэрсайханы асуултад хариулья.

Нэгдүгээр асуудал, гадаадаас ажиллах хүчин авахтай холбоотой харилцаа байгаа юм.

Гадаадаас ажиллах хүчин авах харилцааг Ажиллах хүчний шилжих хөдөлгөөний тухай хуулиар зохицуулдаг. Хуулийн хүрээнд гадаадаас ажиллах хүчин авахдаа уул уурхай болон газрын тосны салбарын шинэ ажилтнуудыг гадаадаас авахад чөлөөлөхгүй, хөнгөлөхгүй гэдэг зохицуулалттай.

Бусад салбарыг хөнгөлж болно гэсэн зохицуулалттай байгаа юм.

Энэ дагуу Засгийн газраас жил болгон гадаадаас авах ажиллах хүчний хязгаарыг тогтоодог. Энэ жилийн хувьд 20.3 мянган шинэ ажиллах хүчин гаднаас авахаар квот тогтоож өгсөн байгаа гэдгийг хэлье.

Нөгөөтээгүүр таны хэлж байгаа салбаруудад гадаадаас ажиллах хүчин авах бол одоо жишээ нь хөнгөлүүлэх эрх нь нээлттэй байгаа. Үүнийг энэ жил журамлаад илүү хялбар болгосон. Шууд манай Хөдөлмөр, халамж, үйлчилгээний ерөнхий газар луу хандаад зөвшөөрлөө аваад энэ дагуу хөнгөлүүлээд энэ шийдвэрийг төрийн захиргааны төв байгууллагадаа шууд гаргадаг ийм зохицуулалт руу оруулсан.

Үүнийг бүтээн байгуулалттай холбоотойгоор. Түүнээс гадна ажиллах хүчний хомсдолтой холбоотойгоор хялбаршуулах чиглэлийг Засгийн газар барьж ажиллаж байгаа гэдэг хэлье.

Хоёр дахь асуудал бол Хөдөлмөрийн тухай хуулийг хэрэгжүүлж эхэлсэнтэй холбоотойгоор гарч ирсэн бас нэг ийм зүйл байгаа юм.

14, 14 буюу уртын ээлжийн зохицуулалт байгаа юм. Энэ дагуу яг таны хэлсэн бэрхшээл үүссэн. Өөрөөр хэлбэл уул уурхайн компаниудад нэг

ээлж нэмэгдэж ажиллахтай холбоотойгоор ажиллах хүчний хомсдол бий болсон. Цаашлаад зарим тохиолдолд тухайн улсууд 14 хоног ажиллачхаад энд 14 хоног ажиллахдаа ахиад ажил хийгээд буцаад очихдоо аваар осолд орох ийм нөхцөл байдлууд үүсэж байна гэдэг зүйл гарсан.

Яг хууль баталж байх үед уул уурхайн үйлдвэрчний эвлэлийн санал 20 мянга гаруй ажилтны саналын дагуу үүнийг бид шийдэх ёстой гэдэг.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Гүйцээгээд хариулчихъя. 5 дугаар микрофон. Ажлын хэсгийн 5-ыг.

С.Зулхар: Энэ туршлагыг бид яах вэ олон улсын туршлага. Нөгөөтээгүүр нийгмийн болон эдийн засгийн талаас нь аваад үзэх юм бол гэр бүлийн харилцаанд ч гэсэн их чухал гэж үзэж гаргасан шийдвэр.

Гэлээ гэхдээ саяынх шиг бэрхшээл үүсгэсэн учраас Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаман дээр ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсгийг би өөрөө ахалж байгаа. Энэ дагуу Үйлдвэрчний эвлэл, Худалдаа, аж үйлдвэрийн танхим, Ажил олгогч эздийн холбоо, бусад төрийн байгууллагуудын оролцоотой бид ажлын хэсэг гаргаад санал, дүгнэлтээ бэлдсэн байгаа.

Өөрөөр хэлбэл үүнтэй холбоотой ямар шийдвэр гаргах вэ, цаашдаа яаж зохицуулах вэ гэдгээр энэ санал, дүгнэлтийг сайдад танилцуулаад Засгийн газрын хуралдаанаар орж энэ саналаа жишээ нь танилцуулах ийм чиглэлтэй байгаа гэдгийг мэдэгдье.

Ц.Сандаг-Очир: Тодруулъя. Б.Дэлгэрсайхан гишүүн.

Б.Дэлгэрсайхан: Төрийн албаны зөвлөлийн дарга Г.Билгүүний тэр шалгалтыг ялгамжтай авъя гэдэгт талархаж байна.

Дээрээс нь мэргэжил таарахгүй гээд байна. Та өөрөө ч гэсэн ийм ийм мэргэжил дутуу гээд. Тухайлбал, Дорноговь аймаг гэхэд Байгаль орчны газрын дарга гээд сумын Засаг даргаар 12 жил ажилласан, төрийн албаны нэлээн туршлагатай ийм хүн томилогдоод. Одоо түр томилогдсон гэдэг юм уу. Ингээд мэргэжлийн бус гээд халаад хаячихсан. Өөрчлөхөөр шийдвэр очсон.

Тэгээд үүнийг бид яах вэ? Мэргэжлийн хүн байхгүй. Бусад мэргэжлийн хүн байна гэхээр нөгөө шаардлагыг нь хангахгүй гээд ийм хайчинд орчхоод байна. Хөдөө орон нутгийн нэг ийм зовлон байна шүү. Үүнийг та нар эргэж хараарай гэдгийг.../минут дуусав/

Б.Чойжилсүрэн: Б.Дэлгэрсайхан гишүүн.

Б.Дэлгэрсайхан: Ийм зовлонгууд ганц Дорноговьд биш олон аймаг, суманд тохиож байгаа байх гэж бодож байна.

Хоёрдугаарт, сая дэд сайдын хэллэгээр үнэхээр уул уурхай, тэгээд бусад ялгаагүй ээлжийн жижүүр энэ тэр чинь одоо бараг л нэг хоног гараад 72 цаг амраад байхаар чинь Монголд үнэндээ ажил хийх хүн байхгүй болчихсон шүү.

Та нар энэ хуулийг өөрчлөлт оруулах асуудлыг Засгийг газраараа оруулаад маш хурдан шийдэхгүй бол гаднаас ямар уул уурхайд ажил хийлгэлтэй биш. Үнэхээр хүнд байгаа. Яагаад вэ гэхээр энэ улсууд ч гэсэн нэг гайгүй цалинтай газар ажил хийчихье гэж

бодох. Гэтэл үнэхээр хүний нөөцийн дутагдалд орчихсон. Монгол Улс.

Тэгээд энэ дээр дэд сайд маань маш яаралтай Засгийн газрын хурлаараа сайдаараа дамжуулаад.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: С.Зулхайр дэд сайд сая Б.Дэлгэрсайхан гишүүний асуусан асуултад хариулаадах.

Ер нь Хөдөлмөрийн хуулийг бид батлахдаа 14, 14 уртын ээлжийг тухайн үед нэг талаас Б.Дэлгэрсайхан гишүүний ажил олгогч талаас харвал ийм байгаа.

Нөгөө талаас ажилтны талаас харвал эрүүл мэнд, гэр бүлийн асуудал талаас нь харж бид хийсэн шүү дээ.

Хөдөлмөрийн хууль чинь өөрөө гурван талт зөвшилцсөний үндсэн дээр хийдэг хууль.

Тийм учраас аль аль нь зөвшилцөөд тухайн үедээ хийсэн хууль. 14, 14 хоногийн уртын ээлжээр ажилладаг чинь бас гэр бүл талдаа бол маш эерэг байгаа шүү дээ. Сэтгэл ханамжтай байгаа шүү дээ.

Хэдийгээр өөрсдөө цалин мөнгө нь буурна гэж ярьж байсан боловч цалин мөнгөнөөсөө илүүтэй гэр бүлийн асуудал, гэр бүл тогтвортой байх асуудал дээр үнэхээр зөв болжээ гэдэг асуудлыг олон ажилчид, олон ажилчдын гэр бүл ярьж байсан учраас тухайн үед Хөдөлмөрийн хуульд ажлын хэсэгт орж ажилласан гишүүний хувьд хэлье гэж бодож байна.

Ш.Адъяаа гишүүн асуултаа асууя.

Ш.Адъяаа: Өнөөдөр Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний

Комиссоос Улсын Их Хуралд тайлан илтгэлээ ирүүлсэн байна.

Улсын Их Хурал үүнийг Хууль зүйн байнгын хороо хэлэлцэж байна.

Жил бүхэн л энэ тайлан илтгэл ирүүлдэг. Одоо бүр өргөтгөөд ингээд хэлэлцэж байгаа юм байна.

Тэгэхээр урд байсан алдаа дутагдлууд дахиад л байж байгаа. Тэгэхээр Хүний эрхийн Үндэсний Комиссоос хүний эрх, эрх чөлөө зөрчигдөж байгаа асуудлаар төрийн холбогдох байгууллагуудад өгсөн тэр зөвлөмж, түүнчлэн шаардлагын хүрээнд хэд нь ханган биелэгдсэн байна? Яг албан ёсоор ийм юм өгсөн, энэ нь биелэгдээгүй, энэ нь биелэгдсэн гэдэг юмыг нэгдүгээрт сонсмоор байна.

Хоёрдугаарт нь, өнөөдөр хөдөлмөрийн асуудалтай холбогдуулж ажил олгогчид, түүнчлэн Засгийн газраас хөдөлмөрийн цалин хөлс, нэмэгдэлтэй холбоотой асуудлыг хөндөж ярьсан. Энэ Засгийн газраас хэрэгжүүлж байгаа бодлого ялгавартай ханддаг, тооцоо судалгаагүй ханддаг асуудлыг Хүний эрхийн комисс ч гэсэн илрүүлж шаардлага тавьсанд сайн хэрэг.

Гэхдээ Засгийн газартай энэ асуудлаар одоо бид Ххүний эрхийн комисс, цаашлаад энэ байгууллагууд нь илтгэл хэлэлцэхдээ бид илрүүлсэн зөрчлийн тухай ярихгүй л гэж бодож байгаа. Шинэ нөхцөл байдлыг л бий болгоё.

Ямар асуудлыг ярья гэхээр зөрчил дутагдал илрүүлээд тэрний мөрөөр авах хэрэг арга хэмжээгээ тухайн байгууллагатай хуулийн хүрээнд ярья. Засгийн газартаа одоо энэ цалин хөлсний асуудал, ялгавартай цалин хөлс олгож

байгаа асуудал, төрийн үйлчилгээний байгууллага, ялангуяа соёл урлагийн байгууллагын асуудал, биеийн тамир спортын байгууллагын асуудлыг энд орхигдуулчихсан байгаа. Засгийн газрын тэр.

Тэгэхээр холбогдох яамтай нь хэдэн удаа уулзалт зохион байгуулаад үүний шийдлийг яаж гаргасан тухай тийм баримт байна уу? Байхгүй бол дараа нь энэ асуудал дээр ийм байдлаар бид явах ёстой гэж бодож байгаа.

Хоёр дахь асуудал. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүд, уул уурхайнууд дээр хөдөлмөрлөх эрхийн асуудал. Тэнд ажиллаж байгаа хүмүүсийн эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай Хүний эрхийн Үндэсний Комисс хэдэн байгууллагаас судалгаа хийж, шалгалт хийсэн бэ? Оюу Толгой гэх мэт.

Одоо энэ дээр би бүр тодорхой жишээ ярья. Ховд аймгийн Дарви суманд байдаг Хятадын 100 хувийн хөрөнгө оруулалттай “Мон Энко” компани гэж байгаа. Тэнд мянга гаруй хүмүүс ажилладаг. Боолын хөдөлмөр эрхэлж байгаа маягтай байна шүү дээ. Тэр дээр ямар дүгнэлт хийх вэ? Газар дээр нь очиж хөдөлмөр эрхлэлт, хүний эрүүл мэнд, аюулгүй байдал, байгаль орчны асуудлаар Хүний эрхийн комисстой би хамтарч явж шалгалт хийх саналтай байна.

Ийм уул уурхай эрхэлдэг гаднын уул уурхайн компаниудтай бид хүний хөдөлмөрлөх эрхийн асуудал, эрүүл орчны асуудлаар Хүний эрхийн комисс цаашдаа энд анхаарч ажиллах ёстой шүү л гэсэн ийм л санал байна.

Тэр хоёр асуултад хариулт.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Ш.Адъяаа гишүүний асуултад Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Д.Сүнжид хариулъя. Ажлын хэсгийн 3 дахь микрофон.

Д.Сүнжид: Зөвхөн хөдөлмөрлөх эрхтэй холбоотойг нь түүх юм бол 18 зөвлөмж, 22 шаардлагыг төрийн албан хаагчидтай холбоотой хүргүүлсэн. Бүгд биелэгдсэн байна.

Нийтэд нь Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Ж.Хунан дарга танилцуулна.

Хоёрт нь, одоо энэ цалин хөлсний ялгаатай байдал, нэмэгдэлтэй холбоотой.

Нэгдүгээрт, энэ илтгэлийн дэд сэдвийн хүрээнд Соёлын яам, Спорт, биеийн тамирын асуудал эрхэлсэн хороо, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, Эрүүл мэндийн яам Нийслэлийн эрүүл мэндийн газар гээд хэлэлцүүлэг зохион байгуулсан. Урьдчилж.

Хоёрт нь, дараагаар нь Ерөнхий сайдын өглөөний уулзалтын Хүний эрхийн Үндэсний Комисс ба иргэний нийгмийн зөвлөлийн гишүүдийн зохион байгуулахад энэ асуудлыг хөндсөн. Энэ дагуу Х.Булгантуяа сайдтай 05 сарын 02, 05 сарын 09-ний өдөр хөдөлмөрийн гурван талт хорооны байгууллагуудтай Үйлдвэрчний эвлэлийн холбоо, Ажил олгогч эздийн холбоо, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай энэ талаар хэрхэн цаашаа ажил хэрэг болгох вэ гэдэг уулзалтуудыг үе шаттайгаар зохион байгуулахаар төлөвлөөд явж байна.

Ц.Сандаг-Очир: Ж.Хунан дарга нэмж. Ажлын хэсгийн 2 дахь микрофон.

Ж.Хунан: Ш.Адьяаа гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээллийн дагуу шалгах ажиллагаа явуулдаг, хяналт шалгалт зохион байгуулдаг.

Үр дүнд нь комиссын гишүүний зөвлөмж, шаардлага явдаг байгаа.

2022 оны хувьд нийтдээ 74 комиссын гишүүний зөвлөмж, шаардлага явсан байгаа.

27 шаардлага, 47 комиссын гишүүний зөвлөмж, мөн комиссын гишүүний зөвлөмж, шаардлага. Ингээд нийлээд энэ гомдол мэдээллийн дагуу 33, комиссын гишүүний санаачилгаар 5 гээд нийтдээ 74 зөвлөмж, шаардлага явсан байдаг.

Өнгөрсөн 2 жилийн хугацаанд нийтдээ 176 албан тушаалтан комиссын гишүүний зөвлөмж, шаардлагыг хүлээж авсан байдаг.

Хариу ирүүлээгүй буюу хэрэгжилтийг хангаагүй нийт 16 албан тушаалтан байгаа.

Комиссын гишүүний зөвлөмж, шаардлагыг хүлээн авсан байгууллагаар нь үзэх юм бол Засгийн газар яам, агентлаг, түүний салбар нэгж 2022 онд Комиссын гишүүний шаардлагыг 7-г авсан байна. Хууль сахиулах байгууллага 5-ыг авсан байна. Нийслэл, орон нутгийн Засаг дарга 7-г, төрийн үйлчилгээ, төрийн өмчит компани 4, хувийн хэвшил 4-ийг авсан байна.

Комиссын гишүүний зөвлөмжийг Засгийн газар яам, агентлаг, түүний салбар нэгж 10-ыг авсан. Хууль сахиулах

байгууллага 8-ыг авсан, нийслэл, орон нутгийн Засаг дарга 61. Энэ нь давхардсан тоогоор орж ирж байгаа гэдгийг хэлбэ.

Өөрөөр хэлбэл 1 зөвлөмжийг нийт 21 аймгийн Засаг дарга, Нийслэлийн Засаг даргад явуулдаг учраас энэ дээр нэмэгдсэн байдлаар орж ирж байгаа юм.

Ц.Сандаг-Очир: С.Зулпхар дэд сайд хариулъя. Ажлын хэсгийн 5 дахь микрофон.

С.Зулпхар: Ш.Адьяаа гишүүний асуултад нэмэлт би эндээс хариулт өгье.

Салбарын төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг рүү шилжсэнтэй уялдуулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хөдөлмөрийн хяналтын чиг үүрэг шилжсэн байгаа.

Үүнтэй уялдуулаад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт 167 хөдөлмөрийн болон нийгмийн хамгааллын байцаагч нар үйл ажиллагаа явуулж байгаа. Энэ дагуу жил болгон хяналт шалгалт хийх ажлын байруудыг Засгийн газраар орж батлуулдаг. Энэ хүрээнд төлөвлөгөөт шалгалтууд хийдэг.

Түүнээс гадна саяын таны хэлсэн төлөвлөгөөт бус. Хэрвээ тэр төлөвлөгөөнд тусаагүй байх юм бол үүнийг бид төлөвлөгөөт бусаар хяналт шалгалт хийх бүрэн боломжтой. Үүнийг бид чиг үүргийнхээ дагуу хөдөлмөр аюулгүй байдал болон хөдөлмөр аюулгүй байдлын эрүүл ахуйн хяналтуудыг хийгээд, дүгнэлт гаргаад, энд шаардлагатай бол зөвлөмж, шаардлагатай бол тодорхой арга хэмжээ авах чиглэл нь байж байгаа гэдгийг танд хэлбэ.

Ц.Сандаг-Очир: Болсон уу?
Ш.Адъяаа гишүүн нэмэлт тодруулга авъя.

Ш.Адъяаа: Гадаадын хөрөнгө оруулалт уул уурхай дээр байгаа тэр асуудлаар хариулт дахиад л авмаар л байх юм. Тэр шалгалт хийгээгүй бол цаашдаа ямар ажил хийх юм бэ гэдэг энэ гол асуудал. Энд л хүний эрх, тэр эрүүл мэндийн асуудал, хөдөлмөр эрхлэлтэй холбоотой хууль зөрчих гэж байгаа гэж үзэж байгаа.

Би түрүүн нэг тодорхой жишээ ярилаа шүү дээ. Тэр “Мон Энко” компани гээд. Тэр дээр өнөөдөр Монгол Улсын Засгийн газартай байгуулсан гэрээ, хүний эрүүл ахуй, байгаль орчин, хөдөлмөрлөх эрхтэй холбоотой асуудлыг өнөөдөр хүртэл үүргээ биелүүлэхгүй байгаа.

Гэтэл өнөөдөр засаг захиргааны байгууллага энэ дээр анхаардаггүй, хүний эрхийн байгууллага энэ дээр анхаарахгүй байгаа. Энэ дээр л анхаарал хандуулж өгөөч ээ.

Тэгээд цаашдаа уул уурхайтай холбоо байгууллагууд дээр, ялангуяа гаднын хөрөнгө оруулалт байгууллагууд дээр хүний эрх, хөдөлмөр, эрхтэй холбоотой асуудлыг л.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн 3 дахь микрофон. Д.Сүнжид хариулъя.

Д.Сүнжид: Ш.Адъяаа гишүүний сүүлийн асуултад нь нэмэлт тодруулга хийе.

Энэ жилийн хүрээнд 2023 онд Оюу Толгой компанид яг энэ хөдөлмөрийн аюулгүй байдал, стандарт, хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилт гэдэгтэй холбоотой хяналт шалгалт хийхээр төлөвлөгөөнд орсон.

Түүнээс гадна эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн хэрэгжилтийг хянахаар хяналт үнэлгээ хийхээр тусгасан. Яг одоохондоо яг уурхайтай бүс, аймгаа сонгоогүй байгаа юм. Тэр тухай танд сонгочоод дараа нь танилцуулья.

Ц.Сандаг-Очир: Ш.Адъяаа гишүүн тодорхой байршилд байгаа гадаадын хөрөнгө оруулалттай компани дээр хамтарсан үзлэг шалгалт хийе гээд байна шүү дээ.

Тэгээд Та бүхэн Ш.Адъяаа гишүүнтэй тусгайлан уулзаад санал бодлоо солилцоорой.

Ганц нэг асуулт асууя. Хүний эрхийн Үндэсний Комиссоос хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх дэд сэдэв нь хөдөлмөрлөх эрх байна.

Тэгээд зөвхөн төрийн албаны хуулийн хүрээнд 225 мянган төрийн албан хаагчдын хүрээнд хийсэн судалгаа, тайлан тавьж байна.

Хувийн хэвшлүүд дээр ер нь Хөдөлмөрлөх эрхийн асуудал хэрхэн яаж зөрчигдөж, хэрхэн яаж хангагдаж байна вэ?

Ажлын байрны дарамтаас авхуулаад цалин мөнгөний асуудал хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээс доошгүй цалингаар цалинжих ёстой. Гэтэл өнөөдөр хувийн хэвшлийнхэн дээр энэ хөдөлмөрийн хуулийн заалт хэрэгжиж байна уу, үгүй юу гэдгээс авхуулаад. Тэгээд нөгөө хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагаа хангаж байгаа юу, үгүй юу?

Энэ асуудал ер нь өнөөдөр яг хувийн хэвшлүүдээр ямар байна вэ? Энэ тал дээр тайланд огт дурдагдсангүй гэж.

Нөгөө талаар саяын Ш.Адъяа гишүүний асуулттай би ойролцоо асуулт байна.

Гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд дээр. Уул уурхай, төмрийн үйлдвэр, энэ барилгын, энэ Оюу Толгой дээр байгаа. Саяхан бас ажил хаяад л, цалин ялгавартай байна гээд л, хөдөлмөрлөх эрх зөрчигдөж байна, авч байгаа цалин өдөр шөнө шиг ялгаатай байна гээд л яриад байгаа юм.

Гадаадын хөрөнгө оруулалттай одоо энэ жил 20 мянга орчим квоттой гэж байна. 20 мянга хүн орж ирээд ажиллах ажлыг манай 20 мянга монгол залуучууд уг нь хийх ажлыг энэ хязгаарлаж гадаадын нөхдүүдээр хийлгэх гэж байна шүү дээ. Цаад утгаараа. Тэгвэл 20 мянга Монгол залуучууд хийх бололцоотой энэ хөдөлмөрлөх эрхийг нь яаж зөрчигдөөд, яаж эрх нь хангагдахгүй байгаа юм бэ? Гадуур захаасаа аваад л ажилгүй залуучууд зөндөө байгаа шүү дээ.

Нөгөө талаар Төрийн албаны зөвлөлийн төрийн захиргааны байгууллага дээр энэ сонгон шалгаруулалт чинь нөгөө талаасаа бас хүний эрхийн зөрчил харагдаж байна уу, үгүй юу. Тухайлбал, анхан шатанд гэдэг юм уу, сумын төв дээр дээд боловсрол төгсөөд ирчихсэн залуучууд дээр заавал тэгээд л сонгон шалгаруулалтыг аваад ингээд л зовоогоод байдаг. Мэргэжлийн индекс гэдэг юмаар хязгаарлаад байдаг. Гэтэл сумын төвд захаасаа аваад ажилгүй залуучууд зөндөө байж байдаг.

Нөгөө талаар төрийн байгууллагууд дээр нь маш олон сул орон

тоонууд бий болоод байдаг. Үүний нийцлийг яаж хангах юм. Нөгөө талаасаа.

4 жил өчнөөн олон зардал гаргаж сурч сурч ирчхээд ирээд мэргэжлийн индекс нь таарахгүй гээд сумын Тамгын газартай төрийн алба хариуцаж чадахгүй байна шүү дээ. Яг үнэнийг хэлэхэд.

Тэгвэл тэрийг чинь анхан шатанд төрийн ажлыг үндсэндээ компьютерын мэдлэг сайтай, харилцаа зан суртахуун сайтай байхад ерөнхийдөө төрийн албыг залгуулаад байх бололцоо боломж байгаа шүү дээ.

Яг нарийн мэргэжил шаардахгүй. Эмч гэдэг юм уу, багш гэдэг юм уу тэр нь л яг мэргэжлийнхээ хүрээнд байх ёстой л байх байлгүй. Өөр нарийн мэргэжил шаардахгүй ажлууд дээр заавал тэгж мэргэжлийн индекс тогтоогоод, ингэж зовоогоод, ингээд хязгаарлаад байх тэр бололцоо нь юу байгаа юм бэ? Энэ дээр Төрийн албаны зөвлөл бодлогоо цаашдаа уян хатан болгооч ээ гэдэг энэ асуулт дээр хариулж өгөөч ээ.

Хүний эрхийн комисс Д.Сүнжид гишүүн хариулах уу?

Д.Сүнжид: Ц.Сандаг-Очир гишүүний асуултад хариулья.

Хувийн салбар дахь хөдөлмөр эрхлэлтийн талаар өнгөрсөн 21 дэх илтгэлдээ тусгасан. Тэгээд энэ нэг дэд сэдвийн хүрээнд авч үзэхдээ ер нь ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаан дахь дарамт, хүчирхийллийн төлөв байдал өөрөө үндэсний хэмжээнд хувийн салбар, төрийн албанд ямар байдаг вэ гэдгийг авч үзсэн юм. Түүгээр л хязгаарласан юм. Яг эрүүл ахуйн стандартыг авч үзээгүй.

Тэгэхээр цаашдаа бид судлахдаа таны хэлээд байгаа хувийн салбар луу

тусгайлаад нөхцөл байдал ямар байгаа юм бэ? Төлөв байдлыг илэрхийлэх ийм судалгаа хийхийг зорино.

Өнгөрсөн жилийн судалгаан дээр хөдөлмөрийн хувийн хэвшлийг авч үзэхээр төрийн болон хувийн хэвшил дарамт хүчирхийллийн хувьд ялгаагүй дүр зураг гарч ирж байгаа. Аль алинд нь байна.

Хамгийн их байдаг нь юу вэ гэхээр сэтгэл санаагаар буюу нэр төрөөр доромжлох, сэтгэл санааны хохирол үзүүлэх, янз бүрийн байдлаар үг хэлэх, ажлаас чөлөөлөгдөө, хийж чадахгүй боль гэдэг асуудал ярих. Үүнд хамгийн их өртдөг гээд 2 хүн тутмын 1 нь хариулсан ийм дүр зурагтай. Энэ нь төрийн алба, хувийн хэвшил аль аль нь адилхан байсан.

Хүний эрхийн Үндэсний Комисст ирж байгаа хамгийн их буюу халдашгүй байх эрх гээд байгаа. Үүнтэй холбоотой гомдол.

Хоёр дахь нь хоёр дахь хамгийн их хүлээж авдаг гомдол бол хөдөлмөрлөх эрх байдаг. Хөдөлмөрлөх эрхийн 246 гомдлын 10-аас 20 хувь нь төрийн албанаас ирдэг. Төрийн албан хаагчдаас. Үлдсэн нь хувийн хэвшлээс ирдэг.

Гол асуудал нь цалин хөлсөө цагтаа өгсөнгүй. Гэрээ байгуулаагүй. Ажлын цагаар илүү ажиллууллаа. Эрүүл ахуйн стандарт хангасангүйгээс би гэм хорын нэхэмжилмээр байна гэдэг энэ асуудлуудыг ярьдаг. Тэр бүхэнд нь шаардлагатай гэж үзвэл хянан шалгалтыг зохион байгуулдаг. Эсвэл хянан шалгах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаад шийдвэрлээд явдаг.

Энэ жилийн тухайд илүү уул уурхайтай холбоотой ийм хяналт

шалгалтыг хөдөлмөрлөх эрхийн хүрээнд зохион байгуулахаар төлөвлөөд байгаа. Энэ талаар танд тухайлан мэдээлэл хүргүүлье.

Ц.Сандаг-Очир: Г.Билгүүн дарга. Ажлын хэсгийн 4 дүгээр микрофон.

Г.Билгүүн: Г.Билгүүн. Ц.Сандаг-Очир гишүүний асуултад хариулья.

Таны ярьдаг мэргэжлийн индексийг хуулиараа Боловсрол, шинжлэх ухааны сайд баталдаг. Төрийн албан хаагчтай яаж холбогдоод байна вэ гэхээр албан тушаалын тодорхойлолт гэдэг юман дээр тавигддаг.

Тийм учраас нөгөө сонгон шалгаруулалттай холбогдоод төрийн албан хаагчийг шилж сонгоход дурдагдаад байгаа юм.

Ер нь 2019 оны 01 сарын 01 хүртэл албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлд ямар нэгэн байдлаар танилцуулгүйгээр, зөвшилцөлгүйгээр тухайн албан тушаалтныг томилдог, чөлөөлдөг эрх бүхий субъект баталдаг байсан.

Тэр үед ямар асуудал гарсан бэ гэхээр томилох гэж байгаа хүндээ тааруулж албан тушаалын тодорхойлолтоо батлаад байна. Жилд 4, 5 өөрчлөөд байна гэдэг ийм гомдол, маргаан тасардаггүй байсан юм билээ.

Үүнийг хууль тогтоогчид олж хараад 2017 оны 12 сард батлагдсан Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгад албан тушаалын тодорхойлолтыг тухайн байгууллага нь боловсруулаад Төрийн албаны зөвлөлд ирж хянуулаад зөвшөөрөл авсны дараа тэр томилдог, чөлөөлдөг эрх бүхий албан тушаалтан нь албан тушаалын

тодорхойлолтоо баталдаг тийм эрх зүйн зохицуулалттай болчихсон.

Амьдрал дээр яаж явж байгаа вэ гэхээр тэр мэргэжлийн индекс гэдэг юмыг Төрийн албаны зөвлөл дээр ирэнгүүт нь бид зохиож тавьдаггүй. Тухайн байгууллага ажлын байрны чиг үүргийн шинжилгээ хийгээд энэ албан тушаал дээр яг ямар мэргэжлийн ямар индекстэй хүн таарах вэ гэдгээ ажлын хэсэг гаргаад боловсруулаад харьяалагдах салбар зөвлөлөөрөө хянуулаад тэгээд төсөл буюу санал нь тухайн байгууллагаас өөрсдөөс нь ирдэг.

Ямар ч гэсэн сүүлийн үед байгууллагаас ирсэн дээр Төрийн албаны зөвлөл энэ хэрэггүй, үүнийг нь хас гэдэг юм уу, үүнийг нь нэм гэдэг юм уу, тухайн байгууллагын анх ирүүлсэн саналыг үл тоомсорлож тэгж байгаа асуудал байхгүй байгаа.

Зүгээр магадгүй.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Ойлголоо.

Хүний эрх, эрх чөлөөний байдлын тайлан илтгэлийн дэд сэдэв Хөдөлмөрлөх эрхийн зарим асуудлаар гишүүд асуулт асууж дууслаа. Үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Үг хэлэх гишүүд. Э.Бат-Амгалан гишүүн.

Э.Бат-Амгалан: Өнгөрсөн 2023 оны 1 дүгээр сард миний бие Шүүх шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж батлуулах ажлын хэсгийг ахалж ажилласны хувьд энэ хуулийн хэрэгжилт дээр энэ хүний эрхийг хангахтай холбоотой хэд хэдэн асуудал дээр санаа зовниж байгаа юм зүгээр.

Энэ талаар би нэг санал гаргах гэсэн юм. Шүүх шинжилгээний тухай

хуулийн шинэчилсэн найруулга батлагдсанаар Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан иргэдийн үндсэн эрхийг хамгаалахад үнэтэй хувь нэмэр болсон гэж ингэж ойлгож байгаа.

Мөн тус шүүх шинжилгээний байгууллагын чиг үүрэг, тогтолцоо, үйл ажиллагаа өргөжиж, цахим технологи, инженер техник, хөрөнгийн болон байгаль орчны хохирлын үнэлгээ, мөн шинжилгээ, сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэл тогтоох зэрэг шинэ төрлийн шинжилгээнүүдийг хийх эрх зүйн орчин нь бүрдээд ажиллаж байгаа.

Өөрөөр хэлбэл шинжээчийн хараат бус байдлыг хангаж өгсөн ийм хуулийн зохицуулалттай төслүүд явж байгаа.

Мөн энэ дээр хэд хэдэн жишээнүүд ярихад хуулийн хэрэгжилт 2023 оны зарим зүйл, хэсэг нь 2023 оны 07 дугаар сарын 01-нээс мөрдөгдөж эхлэхээр явж байгаа.

Жишээ нь, шинжээчийн хараат бус байдлыг хангах зорилготой хэд хэдэн зүйл заалтууд орсон. Шинжээчийг хэн нэгэн дарга томилдог биш программ хангамжаар тохиолдлын маягтай энэ хэргүүд шинжээч дээр томилогддог ийм программ хангамжийн асуудлууд хүртэл байгаад байгаа юм.

Тэгээд өөрөөр хэлэх юм бол шинжээч томилогдохоос эхлээд дүгнэлтээ гаргах хүртэл энэ процесс ямар нэгэн хараат бус байдлаар явах юм. Тэгэхдээ Шүүх шинжилгээний тухай хууль маань харамсалтай нь яах вэ 2023 оны 1 дүгээр сард 2023 оны төсөв батлагдсанаас хойш энэ хууль батлагдчихсан юм.

Тэгэхээр энэ дээр яг юу ярих гээд байна вэ гэвэл 07 сарын 01-нээс мөрдөж эхлэх программ хангамжийн асуудлууд, шинэ тутам орж байгаа тэр цахим технологи, инженер техник хөрөнгийн болон байгаль орчны үнэлгээ шинээр энэ газар хэлтсүүд үүсэн, хуульд заасны дагуу агентлаг дээрээ явах энэ газар хэлтсийн гол төсөв, санхүү, мөнгө нь 2023 оны төсөв дээр сууж өгөөгүй байгаа юм.

Энэ дандаа хүний эрхтэй л холбоотой ийм асуудлууд байгаа.

Тийм учраас Засгийн газрын нөөц хөрөнгөөс Шүүх шинжилгээний хууль батлагдсантай холбоотой Улсын Их Хурлын тогтоолын төсөл дээр Засгийн газрын нөөц хөрөнгөөс гаргаж шийдвэрлүүлэх талаар Улсын Их Хурлын тогтоолын төсөл дээр нэмж тусгуулах саналтай байгаа юм. Үүнийг хэлье гэж бодож байна.

Б.Энхбаяр: Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан гишүүд үг хэлж дууслаа. /алх цохив/

Хөдөлмөрлөх эрхтэй холбогдуулж Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссоос танилцуулсан илтгэлийг хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Одоо Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэлийн Хүүхдийн эрхийн зарим асуудлын талаарх сэдвийн хүрээнд танилцуулгыг Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Ж.Хунан танилцуулна. 2 номерын микрофон.

Ж.Хунан: Хүний эрхийн Үндэсний Комиссоос Хүүхдийн эрхийн асуудалд тусгайлан онцгой анхаарал хандуулдаг.

Үүний нэг илрэл өнгөрсөн хугацаанд нийтдээ 15 удаагийн Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний илтгэлд Хүүхдийн эрхийн асуудлыг үндсэн болон дэд бүлгийн хүрээнд авч танилцуулсан байдаг.

Энэ удаагийн илтгэлд хүүхдийн эрхийн зарим асуудлын хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн дотуур байран дахь хүүхдийн эрхийн асуудлыг хөндсөн.

Энэ хүрээндээ дотуур байран дахь хүүхдийн эсэн мэнд амьдрах эрх, хүүхдийн хөгжих эрх, хүүхдийн хамгаалуулах эрхийн хүрээнд тулгамдаж байгаа асуудлуудыг судалж гаргаж ирсэн байгаа.

Нийтдээ өнгөрсөн онд, мөн 2023 оны эхний саруудад 79 дотуур байранд хяналт шалгалтыг хийсэн. Хяналт шалгалтын явцад анхаарал татсан зайлшгүй шийдэх ёстой асуудлуудыг Та бүхэнд тоймлон хүргэе.

Тэгэхээр хүүхдийн эсэн мэнд амьдрах эрхтэй холбоотой хамгийн нэн тэргүүнд анхаарал татаж байгаа асуудал юу вэ гэхээр дотуур байрны өөрийнх нь нөхцөл байдал байгаа юм.

Тэгэхээр 2021-2022 оны хичээлийн жилд нийт 548 дотуур байр ашиглагдсан. Үүнээс 489 нь стандартын гэж байгаа. 59 нь стандартын бус гэсэн мэдээлэл байна.

Тэгэхээр эндээс бид юу гэж харах гээд байна вэ гэхээр үндсэндээ 1950 оноос ашиглалтад орсон дотуур байр өнөөдрийг хүртэл ашиглагдаж байна гэдэг. Нийтдээ 1990 оноос өмнө ашиглалтад орсон 320 дотуур байр ашиглагдаж байна.

Тэгэхээр энэ хүрээгээрээ яах вэ гэвэл стандартын шаардлага хангаагүй дотуур байранд хүүхдүүд хичээлийн жилд 9 сарыг тэнд өнгөрөөж байна гэдэг ийм мэдээлэл байгаа юм.

Эдгээр байрууд нь ихэнхдээ хуучирсан. Хана туурга нь эвдэрсэн, суулт өгсөн, дээвэр нь цоорсон, ус гоожсон, мөөгөнцөртсөн байдалтай байгаа.

Тэгэхээр эдгээрийг засах шаардлагатай. Нэг бол шинэчлэх. Тэгээд энэ дотуур байрыг ер нь үе шаттайгаар бүгдийг нь шинэчилж ашиглалтад оруулах шаардлага байгаа гэдгийг хэлэх нь зүйтэй.

Дотуур байрны шаардлага хангахгүй байдлаас болоод тэнд хүүхдүүдийн хоол хүнсээр хангагдах эрхэд хамаарах асуудлууд яригдсан. Хөндөгдөж байгаа юм билээ.

Юу гэхээр тэр хадгалах сав байдаггүй. Зориулалтын хадгалах агуулах байхгүй. Үүний улмаас тэр дотуур байранд хоол хүнс хадгалах горим алдагддаг нөхцөл байдал байсан.

Мөн хоол хүнсээр хангагдах эрхийн хүрээнд хоолны илчлэг, дээрээс нь хэмжээ, мөн зардал анхаарал татсан.

Хэдийгээр өнгөрсөн онд хоолны зардлыг нэмэгдүүлсэн ч гэсэн энэ бас инфляцын түвшинтэй уялдаагүй.

Тийм учраас энэ дээр эргэж харах ийм зайлшгүй шаардлагатай байгаа.

Хүүхдийн эсэн мэнд амьдрах эрхийн хүрээнд мөн цэвэр усаар хангагдах эрхийн асуудал анхаарал татсан хэвээр байгаа. Анхаарал татсан.

Дотуур байрны сурагч өдөрт 2 литрээс доошгүй ундны ус уух боломжоор хангагдсан байх ёстой гэдэг боловчиг яг бодит байдал дээр Хүний эрхийн Үндэсний Комиссын хийсэн хяналт шалгалтад хамрагдсан дотуур байруудын хувьд энэ учир дутагдалтай байсан.

Усыг зөөвөрлөдөг. Нэг бол төвийн шугамд холбогдсон. Тэгээд аж ахуйн нэгж цэвэршүүлэгч холбосон байдаг. Гэхдээ тэр цэвэршүүлэгчийн шүүлтүүрүүдийг нь хэзээ сольсон, хэзээ сольдог, энэ талаар нарийн зохицуулсан хэм хэмжээ зохицуулалт байхгүй байсан.

Дараагийн анхаарал татсан асуудал бол энэ эмнэлгийн тусламж авах эрхийн хүрээнд хэд хэдэн ноцтой асуудлууд ил болсон. Өөрөөр хэлбэл хяналт шалгалтад хамрагдсан 79 сургуулиас 9 сургуульд зайлшгүй байх эмийн жагсаалтад байдаг эмийн хугацаа нь дууссан нөхцөл байдал байсан.

Тэгээд үүнийг яагаад солиогүй юм бэ гэдэг дээр төсөв байхгүйн улмаас үүнийг нөхөж татан авалт хийгээгүй.

Дээрээс нь үүнээс гадна энэ хугацаа нь дууссан эмийг устгах устгасан талаарх баримт мэдээлэл байхгүй. Тэгээд бүртгэл нь байдаггүй зөрчлүүд илэрсэн. Мөн эрүүл мэндээ хамгаалуулах, эрүүл мэндийн эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах эрхийн хүрээнд ялангуяа орон нутаг, суманд байдаг дотуур байранд эмчийн хүрэлцээ хангалтгүй. Эмчээс гадна бүр нарийн хүүхдийн эмчийн хүрэлцээ байдаггүй ийм нөхцөл байдал байсан.

Тийм учраас хүүхдийн эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах эрх зөрчигдөх бодитой эрсдэл байна гэж комиссоос дүгнэсэн байгаа.

Мөн дараагийн анхаарал татсан асуудал бол энэ хувийн орон зайгаа хамгаалуулах эрхийн хүрээнд гарч ирсэн. Энэ нь юу вэ гэхээр дотуур байранд хүүхдүүд хаалгаа дотроос нь цоожлох боломжгүй дотуур байрууд байсан. Өөрөөр хэлбэл сургуулийн дотуур байрны захиргаанаас цоож тавиагүй. Хэн дуртай нь нэвтрэх боломжтой нөхцөл байдалтай. Энэ нь хүүхдүүдэд нөгөө хувийн орон зайгаа хамгаалуулах, дээрээс нь халдашгүй дархан чөлөөтэй байх энэ эрхийг зөрчиж байгаа, энэ эрхийг эрсдэлд оруулж байгаа ийм шаардлага, зохицуулалт байгаа.

Үүнээс гадна дотуур байран дахь ариун цэврийн өрөө, тасалгаанууд гаднаасаа харагдах байдлаар зохион байгуулсан гэх юм уу, аль эс үгүй ийм нөхцөлтэй байсан. Өөрөөр хэлбэл хөшиг татаагүй. Тэгээд хамгаалалтын хуулга наагаагүй. Наасан ч гэсэн тал наасан байдлаар ариун цэврийн өрөөг тохижуулсан байсан.

Энэ нь гаднаас зураг авах, бичлэг хийх ийм бүрэн боломжтой ийм нөхцөл байдлыг бий болгож байсан.

Анхаарал татсан бас нэг асуудал буюу ноцтой асуудал бол охидын өрөөнд камер байршуулсан, хяналтын камер байршуулсан явдал байсан. Энэ нь мэдээж хэрэг ялангуяа өсвөр насны охидуудын хувьд хувцсаа солиход маш хүндрэлтэй байдаг.

Энэ зөрчил бас хэд хэдэн дотуур байранд гарсан гэдэг мэдээллийг сүүлд энэ олон нийтийн сүлжээнд ч бас гарч байгаа, гарсан ийм асуудал байна.

Тэгэхээр үүнийг нэг мөр цэгцлэхгүй бол камерыг дотуур байрны хүүхдүүдийн өрөөнд байрлуулах нь

өөрөө маш том хүүхдийн эрхийн зөрчил гэж харж байгаа.

Хяналт шалгалтад хамрагдсан 79 дотуур байрны 39-д нь налуу зам байсан. Өөрөөр хэлбэл хүртээмжтэй. Тэнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сурч амьдрах нөхцөл боломжийг бүрдүүлсэн. Бусад нь байгаагүй.

Тийм учраас энэ дээр анхаарах хэрэгтэй. Хүрэлцээтэй, хүртээмжтэй орчныг бүрдүүлэх. Дээрээс нь дотуур байр нь өөрөө тийм байх нь ганц хөгжлийн бэрхшээлтэй биш бас тэнд очиж байгаа, дотуур байранд хүүхдүүдээ эргэж байгаа эцэг эх, эмээ өвөө нарт ийм ээлтэй орчныг бүрдүүлнэ гэж харж байгаа.

Хүүхдийн хөгжих эрхийн хүрээнд ихэнх дотуур байрууд интернэт сүлжээ байхгүй. Өөрөөр хэлбэл интернэтэд орох боломж нь хязгаарлагдмал байсан.

Тэгэхээр үүнийг бид хүний эрхийн зөрчил, хүний эрхийн хязгаарлалт гэж дүгнэж байгаа. Яагаад гэвэл интернэт орох эрх хүний эрх байдаг. Тэндээс мэдээлэл олж авах, мэдээлэл хайх, дээрээс нь оюутан, сурагчдын хувьд хичээл ном, сургалт, даалгавраа хийх нөхцөл боломжийг бүрдүүлдэг учраас энэ бол зайлшгүй байх ёстой зүйлийн нэг гэж харж байгаа.

Тэгээд энэ хүүхдийн хөгжих эрхийн хүрээнд нийт 54 дотуур байранд хүүхэд хөгжлийн өрөөтэй байсан. Бусад нь байхгүй.

Тэгэхээр энэ нь нөгөө хүүхэд чөлөөт цагаараа ороод хичээл даалгавраа хийх, бусад байдлаар тоглоом наадгай тоглох энэ боломж нь хязгаарлагдсан байна гэж харсан байгаа.

Кабелийн телевиз хэдийгээр байдаг боловчиг төлбөр нь төлөгддөггүй. Дээрээс нь энэ цагийн хязгаартай ийм зохицуулалтууд байсан.

Тийм учраас үүнийг харах хэрэгтэй.

Дотуур байранд гарч байгаа гэмт хэрэг, зөрчил нэлээдгүй байна. 2022 оны хувьд 11 гэмт хэрэг гарсан байна. 19 зөрчлийн хэрэг бүртгэгдсэн байгаа. Хүүхдийн 108 утсанд гомдол ирсэн.

Нийт дотуур байрны хүрэлцээтэй холбоотой хүрэлцээ хангалтгүй гэсэн 15 гомдол ирсэн байгаа. Дотуур байран дахь үе тэнгийн дээрэлхэлттэй холбоотой 6 гомдол ирсэн байна. Багш, ажилчдын зүй бус харьцаатай холбоотой 17 гомдол, ялгаварлан гадуурхалтай холбоотой 3, үл хайхрах хүүхдийн хүчирхийлэлтэй холбоотой 3, мөнгө нэхэх 2, хулгайтай холбоотой 3 гомдол хүүхдийн 108 утсанд ирсэн байна.

Дотуур байранд мөн анхаарал татсан бас нэг асуудал бол энэ камерын хяналтын асуудал байгаа.

Тэгэхээр камерын хяналт гадна дотно орчинд хангалтгүй байсан.

Тэгэхээр нийтийн эзэмшлийн талбайд камерын хяналт байхгүй байгаа нь хүүхэд өөрөө хүчирхийлэлд өртөх бусад үе тэнгийнхний дээрэлхэлд өртөх нөхцөлийг бий болгож байна.

Тийм учраас камерын хяналтыг сайжруулах, ялангуяа камерын хяналтгүй нийтийн эзэмшлийн талбайг байхгүй болгохыг зорих хэрэгтэй.

Камерын хяналттай холбоотой мөн анхаарал татсан асуудал бол үүнийг хэрхэн ашиглах талаар журам хангалттай

байгаагүй. Өөрөөр хэлбэл 30 дотуур байранд камерын хяналтын журмыг баталсан. Энэ нь хэрхэн бичлэгийг үзэх, хэн бичлэгийг үзэх эрхтэй гэдэг зохицуулалтыг багтаасан журам байна.

Камерын бичлэгийн хувьд ихэнх нь 7-оос 14 хоногийн хугацаанд хадгалдаг. Өөрөөр хэлбэл урт хугацаанд хадгалаад үүнийг нөхөн үзэх боломж хязгаарлагдмал байдаг. Магадгүй үүнтэй холбоотой аливаа зөрчлийг дараа нь нягтлах боломж нь хязгаарлагддаг байж болзошгүй гэж.

Дотуур байр болгон хүүхэд хамгааллын бодлогыг баталж хэрэгжүүлэх ёстой байдаг.

Тэгээд дотуур байрнууд ихэнх нь бүгдээрээ бодлого, хөтөлбөрийг баталсан байсан боловчиг төлөвлөгөөг хэрэгжүүлэх төсөв, санхүүжилт байдаггүйн улмаас тэдгээр нь хэрэгждэггүй гэсэн дүгнэлтийг Хүний эрхийн Үндэсний Комиссоос хийсэн байгаа.

Тэгээд эдгээр нөхцөл байдлыг үндэслэж Хүний эрхийн Үндэсний Комиссоос дотуур байртай холбоотой 5 саналыг гаргаж байгаа.

Нэгтгэвэл стандартын шаардлага хангахгүй байгаа ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрын жагсаалтыг гаргаж, тэгээд шинэчлэх төлөвлөгөө гарган санхүүжилтийг шийдвэрлэх шаардлагатай юм байна.

Хоёрт нь, дотуур байрны гадна болон дотно орчны аюулгүй байдал, хоол хүнс, цэвэр усны хэрэглээнд эцэг эхийн оролцоотой хөндлөнгийн хяналт тавих тогтолцоог бий болгох зайлшгүй шаардлагатай юм байна гэж харсан.

Тийм учраас энэ саналыг гаргаж байгаа.

Мөн дотуур байр дахь хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг орон нутгийн төсөвт заавал тусгадаг болох саналыг гаргаж байна.

Дотуур байрын багшийн албан тушаалыг ерөнхий боловсролын сургуулийн багштай дүйцүүлэх. Мөн дотуур байранд ажиллах туслах эмч, сэтгэл зүйч, тогооч, жижүүр, үйлчилгээний ажилтны орон тоог дотуур байрын хүчин чадал, сурагчдын тоотой уялдуулан баталж, цалин хөлсийг нэмэгдүүлэх, нийгмийн баталгааг сайжруулах саналыг гаргаж байгаа.

Тавд нь, дотуур байрын багш болон ажилчдыг тусгайлан чадавхжуулах хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай юм байна.

Орон нутгийн холбогдох эрх бүхий байгууллагуудын уялдаа холбоотой ажиллах хамтын ажиллагааг сайжруулах гэдэг саналыг гаргаж байгаа.

Хүүхдийн эрхийн хууль зүйн хороотой холбоотой Хүний эрхийн Үндэсний Комиссоос 2020, 2023 онд нийт 23 хүүхдийн эрхийн хууль зүйн хороонд хяналт шалгалтыг хийсэн байгаа.

Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо хүүхэд хамгааллын бүтцийн нэг шинэ механизм гэж харж байгаа.

2016 онд Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль батлагдаж энэ хуульд заасны дагуу аймаг, дүүргүүдэд Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо байгуулагдан гэмт хэргийн холбогдогч, гэмт хэргийн хохирогч, гэмт

хэргийн гэрч хүүхдэд туслалцаа үзүүлэх чиг үүрэгтэй хороод байгаа.

Шинэ болон чухал бүтэц. Гэсэн хэдий ч энэ бүтцийн үйл ажиллагаа хангалтгүй. Үйл ажиллагаатай холбоотой гомдол, мэдээлэл. Дээрээс нь Хүний эрхийн Үндэсний Комиссоос хийсэн хүчирхийллээс ангид байх эрхийн хүрээнд хийсэн хамтарсан багийн үйл ажиллагааны шалгалтын үр дүнд үүнийг зайлшгүй үзэж үйл ажиллагаанд нь хяналт шалгалт хийх ёстой юм байна гэдэг дүгнэлтийг үндэслэж үүнийг хийсэн байгаа.

Тэгээд Хүүхдийн эрхийн хууль зүйн хороотой холбоотой 2021 онд үнэлгээ хийгдэж. Тэгээд энэ Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүтцийг шинэчилсэн байдаг.

Тэгэхээр 2017 онд байгуулагдсан Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо бол үндсэндээ энэ бүтэц, бүрэлдэхүүн нь үр дүн муутай юм байна гэдэг дүгнэлтийг 2021 онд хийсэн үнэлгээгээр хийсэн юм байна лээ.

Тэгээд өмнө нь 2021 оноос өмнө Хүүхдийн эрхийн хууль зүйн хороог Хууль зүйн хэлтсийн дарга ахалдаг байсан. Тэгээд энэ нь бас төдийлөн үр дүнтэй биш байсан учраас 2021 онд дүрмийг шинэчилж баталсан.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан тушаалаар баталсан дүрмээр аймаг, дүүргийн Засаг даргын орлогч Хүүхдийн эрхийн хууль зүйн хороог ахалдаг болсон байгаа.

Тэгээд дээрээс нь бүрэлдэхүүний хувьд 13-аас 17 хүнтэй байхаар заасан. Хэд хэдэн гишүүн нэмэгдсэн. Үүн дээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг

зохицуулах салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга, аймаг, дүүргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга, аймаг, дүүргийн хүүхдийн элч зөвшилцсөнөөр бүрэлдэхүүнд нь шинээр орсон байгаа.

Гэсэн хэдий ч өнгөрсөн хугацаанд буюу 2022 онд энэ Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны ажилласан байдалд тайлагнасан байдал бас хангалтгүй байсан гэж дүгнэсэн. Хүний эрхийн Үндэсний Комиссоос.

Хороо нь жилийн төлөвлөгөөнөөс гадна хүүхдийн эрх хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах боломжийг бүрдүүлж, сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах ёстой байдаг.

Гэмт хэрэг, зөрчилд холбогдсон шалгагдаж байгаа хүүхдийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны сөрөг нөлөөллөөс хөндийрүүлэх зорилгоор хууль сахиулах байгууллагатай хамтран ажиллах арга хэмжээний төлөвлөгөөг гаргах ёстой, батлах ёстой байдаг.

Тэгэхээр эдгээрийг гаргадаггүй, баталдаггүй.

Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад хүмүүжиж байгаад суллагдсан хүүхдийг нийгэмд хэвийн амьдрахад нь дэмжлэг туслалцаа үзүүлэх, хууль зөрчсөн хүүхдэд зөв хүмүүжил олгох, хорт зуршлаас ангижрахад нь чиглэгдсэн боловсрол, мэргэжил, мэргэжлийн чиг баримжаа олгох, амьдрах ухаан, эрх зүйн анхан шатын мэдлэг олгох сургалт зохион байгуулах, төлөвлөгөөг батлах ёстой боловч үүнийгээ баталдаггүй.

Мөн хорооны гишүүд болон хамтран ажилладаг байгууллагуудын

алба хаагчдыг чадавхжуулах хөтөлбөрийг...

Б.Энхбаяр: 20 минут хүрч байна. 15 минут багтааж танилцуулах ёстой. Тийм.

Танилцуулгыг танилцаж дууслаа.

Хүүхдийн эрхийн зарим асуудал сэдэвтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Ц.Сандаг-Очир гишүүнээр тасаллаа. Б.Энх-Амгалан гишүүнээр тасаллаа. Б.Дэлгэрсайхан гишүүн асуултаа асууя.

Б.Дэлгэрсайхан: Хүний эрхийн комиссын хүүхдийн талаарх илтгэлийг сонслоо.

Тэгээд дотуур байр, энэ юу энэ тэр гээд нэлээн зөрчлийн асуудал ярьж байна л даа. Зүгээр энэ хөдөө орон нутагт ийм байна уу? Хотод ийм нийтлэг байна уу?

Хамгийн гол юм чинь дунд сургуулийн хүүхдийн бэлгийн хүчирхийллийн асуудал чинь бүр газар авлаа шүү дээ. Үүнийг юу гэж ойлгож. Энэ талаар ер нь Хүний эрхийн комисс тийм судалгаа байна уу? Үүнийг ерөөсөө ярьсангүй. Та нар.

Тэгээд хөдөө орон нутагт, та нар бараг мэдэж байгаа байх даа. Улс маань ер нь хаашаа л яваад байна даа. Энэ дунд сургуулийн хүүхдүүд нөхөрт гарч байна шүү дээ. Мэдэж байгаа юу? Үүнийг ер нь. Тэгээд ганц Дорноговьд ийм байгаа юм уу гээд ингээд гишүүдээс танай аймгуудаар ямар байна гэхээр яг адилхан гэх юм. Улсын хэмжээнд ийм хараа хяналтгүй ч гэдэг юм уу, эсвэл амьдралын тэр юунаасаа хамаардаг юм уу, орлого, янз бүрийн юмнаасаа хамаардаг юм уу.

Тэгээд дээрээс нь дунд сургуулийн хүүхдийн жирэмслэлт газар авсан. Бүгдээрээ мэдэж байгаа.

Тэгээд үүнийг яах юм бэ хэдүүлээ? Энэ чинь Монголын эмгэнэл боллоо шүү дээ. Тэгээд энэ хүүхдүүд чинь ямар дунд сургуульд ямар хүүхэд гаргалтай биш. Хүссэн хүсээгүй л үр хөндөлт хийлгэж байгаа шүү дээ. Тэгээд цаашдынх нь хувь заяаг яах юм? Энэ талаар сургалт юм байна уу?

Арай эрт үед хэдэн жилийн өмнө уг нь дунд сургуульд эрүүл мэндийн хичээл гэж ордог байсан юм. Үүнийг аваад хаячихсан. Одоо үүнийг буцааж тэр эрүүл мэндийн хичээл, эрүүл мэндийн мэдлэг боловсролтой болгох. Ядахдаа бэлгийн амьдрал ийм байх ёстой гээд тэр юмыг нь заадаг, өвчин зовлонгоос хол байх энэ юмыг нь заадаг юмыг нь бүр Боловсролын хуульдаа хийж өгдөг юм уу.

Тэгээд Хүний эрхийн комисс энэ талаар тийм сургалт судалгаа явуулж байгаа юм бий юу? Ийм ноцтой бүр нийгэмд эмгэнэл болж байгаа юмаа л хэдүүлээ яримаар байх юм. Түүнээс биш энэ дотуур байрны шил нь хагархай, жорлон нь тал, наалттай энэ тэр гээд тийм сургуулийн захирлын юм яриад хэдүүлээ. Тийм биз дээ.

Жоохон том юм ярихгүй бол. Энэ чинь одоо үнэндээ цаана чинь бараг дотуур байрнаас илүү ноцтой эмгэнэл болчхоод байна шүү дээ. Яг үнэндээ. Бүгдээрээ мэдэж байгаа.

Тэгээд очоод цэрэг, цагдаагийнхаа дарга эрүүл мэндийн газрын даргаа дуудаад үгүй энэ чинь юу болж байна гээд асуухаар гомдол ирээгүй байна шүү дээ. Одоо тэгээд яах юм бэ. Бид чинь

шалгаж болох болохгүй шүү дээ гээд. Гомдол ирээгүй нь ч үнэн л дээ.

Тэгээд нэг ийм л юм болчхоод байгаа юм. Тэгээд хэдүүлээ яах ёстой юм? Энэ дээр л Хүний эрхийн комисс юу бодож байгаа юм?

Тэгээд зарим нь ч нууцаар үр хөндүүлж байх шиг байна. Зарим нь ч эцэг эх нь бодвол тэгээд л хэлээд л очдог л байх.

Тэгээд үүнийг л хэдүүлээ тойрч яримаар байгаа юм даа. Энэ бол Монголын эмгэнэл болсон шүү. Яг үнэндээ бол. Тэгээд үүнд Хүний эрхийн комиссынхон эсвэл энд хамаатай Эрүүл мэндийн яамнаас мэдэж байгаа.../минут дуусав/

Б.Энхбаяр: Нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга Д.Баярболд оролцож байгаа юм байна. Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Оюунчимэг оролцож байгаа юм байна. Боловсролын ерөнхий газрын дарга Т.Ням-Очир оролцож байгаа юм байна.

Ж.Хунан даргаас асуух уу? Ж.Хунан дарга Б.Дэлгэрсайхан гишүүний асуултад хариулъя. 2 номер.

Ж.Хунан: Б.Дэлгэрсайхан гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр Хүний эрхийн Үндэсний Комисс 21 дэх илтгэлдээ хүчирхийллээс ангид байх эрхийн хүрээнд хийсэн судалгаа, хяналт шалгалтын үр дүнг танилцуулсан.

Энэ хүрээнд бэлгийн хүчирхийллийн хохирогч хамгааллын асуудлыг хөндсөн. Өөрөөр хэлбэл

хамтарсан баг нэг цэгийн үйлчилгээ, хамгаалах байртай холбоотой асуудлыг хөндөж тусгасан байгаа.

Үүний дагуу холбогдох саналыг гаргасан байгаа.

Өнөөдрийн илтгэлд ярилцаж байгаа энэ Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны нэг үндсэн чиг үүрэг яг энэ гэмт хэргийн хохирогч болсон хүүхдүүдэд туслалцаа үзүүлэх асуудал байгаа юм.

Тэгэхээр энэ уг нь их хэрэгтэй бүтэц. Тэгэхдээ ажиллахгүй байгаад асуудал байгаа юм.

Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны өнгөрсөн 2022 оны төсөв 200 сая төгрөг байгаа юм.

Тэгэхээр энэ нь хангалттай төсөв биш. Энэ төсвийн ихэнх нь сургалтад зарцуулагдсан ийм төсөв байгаа юм.

Хүний эрхийн Үндэсний Комиссоос хүүхдийн эрхийн асуудлын хүрээнд хүүхдийн эсрэг бүх төрлийн хүчирхийллийн асуудлыг судалж холбогдох газарт нь тухай бүр нь өгч ажиллаж байгаа.

Ялангуяа орон нутагт энэ орон нутаг, сумуудад байгаа дотуур байртай холбоотой, магадгүй хөшиг байхгүй, хаалт байхгүйн улмаас дотуур байран дахь хүүхдүүд хүчирхийллийн хохирогч байж болзошгүй нөхцөл байдал байна. Энэ хоорондоо уялдаа холбоотой байж болзошгүй гэдгийг хэлэх нь зүйтэй байх.

Тэгэхээр энэ дотуур байрны асуудлыг бид анхаарах ёстой байгаа юм.

Тэгэхээр үүнээс улбаалаад магадгүй тэнд нөгөө хяналт байхгүйгээс дотуур байрны хүүхдүүд хүчирхийлэлд

өртөх эрсдэл байна гэдгийг хэлээд байгаа юм.

Сургалтын хувьд Хүний эрхийн Үндэсний Комиссоос хүний эрхийн боловсролыг олгодог сургалтыг албан сургалтын тогтолцоонд бүр ингээд албан ёсоор оруулъя. Бага наснаас нь тухайн насны онцлогт таарсан байдал хэлбэрээр хүний эрхийн сургалтыг оруулдаг болъё гэдэг зүйлийг ярьж байгаа.

Мөн үүнээс гадна албан бус байдлаар Хүний эрхийн Үндэсний Комиссоос тогтмол сургалтыг зохион байгуулж байна. Цагдаагийн байгууллагатайгаа мөн бусад хүний эрхийн төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтраад сургалтыг тогтмол зохион байгуулж ирж байгаа.

Тэгээд харамсалтай нь хүүхдийн эрхийн зөрчил буюу хүүхдийн эсрэг хүчирхийлэл, бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэг гарсаар байгаа.

Б.Энхбаяр: Б.Дэлгэрсайхан гишүүний асуултад ч хариулсангүй дээ.

Өөр юм ярьсаар байгаад л өнгөрчихлөө. Нэмж хариулъя. Б.Дэлгэрсайхан гишүүн тодорхой асуулт асуугаад байгаа юм. П.Болормаа Цагдаагийн ерөнхий газрын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, цагдаагийн дэд хурандаа.

П.Болормаа дарга 4 номерын микрофонд хариулъя. 10 номер. Хэн билээ? Д.Баярболд дарга дараа нь хариулна шүү. 1 номерт суучхаарай. 4 номерын микрофоныг өгье.

П.Болормаа: 2023 оны эхний 3 сарын байдлаар насанд хүрээгүй хүний эсрэг үйлдэгдсэн хүчиндэх гэмт хэрэг 80 бүртгэгдсэн байгаа.

Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 17 хувиар өссөн үзүүлэлттэй байгаа.

Харин насанд хүрээгүй хүнээс үйлдсэн гэмт хэрэг 179 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 43 хувиар буурсан. 518 хүүхэд хохирсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2 хувиар буурсан үзүүлэлттэй байгаа.

Өнгөрсөн 2022 онд 2014 хүүхэд гэмт хэргийн улмаас хохирсон нь 30 хувиар өссөн үзүүлэлттэй байгаа.

Насанд хүрээгүй хүүхдийн эсрэг хүчиндэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр цагдаагийн байгууллагаас соён гэгээрүүлэх нөлөөллийн ажил болон мэдээлэл сурталчилгааны ажил, сургалтын ажлыг Боловсролын ерөнхий газар болон бусад нутаг дэвсгэрийн хамтарсан багаар сургалт, сурталчилгаа, мэдээллийг өргөн хүрээтэй тогтмол зохион байгуулж байгаа.

Мөн насанд хүрээгүй хүний эсрэг үйлдэгдэж байгаа гэмт хэргийн шалтгаан, нөхцөл байдлыг авч үзэхээр хамгийн нэгдүгээрт гэр бүлийн хамаарал бүхий этгээдээс үйлдсэн гэмт хэрэг нь 70 хувийг эзэлж байгаа. Энэ нь ёс суртахуунтай холбоотой байна.

Мөн гэр бүлийн салалт, архидан согтуурсан, ёс зүй, хүмүүжил, төлөвшилтэй холбоотой асуудал байна. Эцэг, эхийн хараа хяналт сул, архины хамааралтай ажилгүйдэл гэх мэт шалтгаан нөхцөлүүд нөлөөлж байгаа тоон үзүүлэлттэй байна.

Б.Энхбаяр: Нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга Д.Баярболд 1 номерын микрофонд нэмж хариулья.

Дараа нь, М.Цогтбаатар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн дарга хариулна шүү. Энэ гэр бүл төлөвлөлт. Т.Ням-Очир дарга хариулчих юм уу?

Боловсролын ерөнхий газрын дарга Т.Ням-Очир дарга та 4 номерт суучхаарай.

Ер нь энэ гэр бүл төлөвлөлттэй холбоотой. Тэндээсээ ярьчих юм байна. 1 номерын микрофон. Д.Баярболд дарга.

Д.Баярболд: Б.Дэлгэрсайхан гишүүний асуултад хариулья.

Эрүүл мэндийн яамны Нийтийн эрүүл мэндийн газрын дарга Д.Баярболд байна.

Монгол Улсад сүүлийн 5 жилийн байдлаар 462 мянга 474 эх амаржсанаас 4.7 хувь буюу 21 мянга 900 нь өсвөр насны охид байна гэсэн статистик гарсан байгаа.

Өсвөр насны төрөлтийг өмнөх онуудтай харьцуулахад 2020 онд 0.5, 2021 онд 0.3 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Мөн жирэмсэн өсвөр насны охид, тэдний асран хамгаалагчид жирэмслэлтийг шийдвэрлэх, жирэмслэлтийн хяналт, үр хөндөлт, үр хөндөлтийн өмнө ба дараах жирэмслэлтээс хамгаалах арга хэрэгслийн зөвлөгөө, мэдээллийг эрүүл мэндийн байгууллага тухай бүр үйлчилдэг.

Шийдвэрийг охид өөрсдөө, тэдний асран хамгаалагчдын дэмжлэг дээр гаргаж шийдвэрийнхээ дагуу тусламж, үйлчилгээнд хамрагддаг байна.

2021 оны байдлаар үр хөндөлтийн 12 мянга 43 тохиолдол бүртгэгдсэн. Мянган амь төрөлт нь 168.1 байгаа нь өмнөх онтой харьцуулахад 23.6-аар буурсан.

Үр хөндөлтийн 4.7 хувь нь өсвөр насны үр хөндөлт байна.

2018 оноос эрүүл мэндийн хичээлийн агуулгад нийтдээ 6 төрлийн агуулгыг оруулсан. Энэ агуулгын хүрээнд 6-аас 12 дугаар ангид долоо хоногт 1 цаг буюу жилийн турш 35 цагийн эрүүл мэндийн хичээл орж байгаа.

Энэ хүрээнд өсвөр үеийнхэнд бэлгийн болон нөхөн үржихгүйн эрүүл мэндийн талаар ойлголт, тэдэнд зориулсан хөтөлбөр боловсруулан сургалтаар дамжуулан хүргэгдэж байгаа.

Эрүүл мэндийн байгууллагаас тавьж байгаа шаардлагын хувьд энэ хичээлийг мэргэжлийн бус хүнээр оруулдаг. Бас алдаг оног ордог ийм асуудал байгаа.../минут дуусав/

Б.Энхбаяр: Т.Ням-Очир Боловсролын Ерөнхий газрын дарга. 7 номерын микрофон нэмж хариулья.

Т.Ням-Очир: Б.Дэлгэрсайхан гишүүний асуултад хариулья. Боловсролын ерөнхий газрын дарга Т.Ням-Очир.

Сая Д.Баярболд дарга төгсгөл дээрээ хэлчихлээ.

Тэгээд ер нь 1998-2014 оны хичээлийн жилд Монгол Улсын ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрт эрүүл мэндийн хичээлийн агуулга заавал судлах агуулгаар тусаад явж байсан.

Тэгээд 2014 оноос эхлээд иргэний боловсрол, эрүүл мэндийн хичээл гээд хүүхдийг хүн болгох, эрүүл аж төрөх ёсны хичээлүүдийг бусад хичээлийн агуулгуудтай интеграц ажиллах байдлаар заавал судлахаас сургуулийн хичээлээс гадуурх үйл ажиллагааны цагт тавьснаас шалтгаалж өсвөр үеийнхний ёс зүй, эрүүл мэндийн асуудал нэлээн хөндөгдсөн.

Тийм учраас 2018-2019 оны хичээлийн жилд тухайн үеийн У.Хүрэлсүхийн Засгийн газар эрүүл мэндийн хичээлийг заавал судлах цагаар, иргэний ёс зүйн боловсролын хичээлийг заавал судлах цагаар оруулах шаардлагатай гэж үзэж тухайн үед ажлын хэсэг байгуулагдаж, 2019-2020 оны хичээлийн жилээс эхлээд эрүүл мэндийн хичээл, 2020-2021 оны хичээлийн жилээс иргэний ёс зүйн боловсролын хичээлийг сургалтын төлөвлөгөөнд тусгаж, заавал судлах агуулгаар судалж эхэлсэн.

Тэгээд саяын Д.Баярболд даргын хэлсэнчлэн 6 багц агуулга байгаагийн 1 агуулга нь бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд гэсэн агуулга судлагдаад явж байгаа.

Тэгээд Та бүхэн санаж байгаа бол 2020-2021 онд КОВИД-ын үед эрүүл мэндийн хичээлийн агуулгуудыг цахимаар телевизийн хичээлээр зааж эхлэхэд энэ дээр гэр бүл төлөвлөлттэй холбоотой, үр хөндөлттэй холбоотой, жирэмслэлтээс хамгаалах холбоотой агуулгууд телевизээр заагдаад ирэхэд насанд хүрэгчид энэ агуулга руу оролцож яагаад өсвөр насны хүүхдүүдэд ийм агуулга зааж байгаа юм, яагаад ийм

агуулга орох ёстой юм гэдэг байдлаар хандаж.

Тэгээд энэ агуулгуудын сайжруулалтууд хийгдэж явсан.

Мөн сая Д.Баярболд даргын хэлсэнчлэн энэ хичээлийг дурын багш заагаад байна. Бэлтгэгдсэн багш байхгүй байгаагаас агуулга бүрэн хүрэхгүй байна гэдэг асуудлууд яригдсан учраас эрүүл мэндийн багшаар бэлтгэгдсэн болон биологийн багшийг давтан бэлтгэж энэ агуулгуудыг зааж байгаа учраас одоо энэ асуудал дээр цэгцлэгдээд явна гэж харж байгаа.

Дээрээс нь саяхан ерөнхий боловсрол.../минут дуусав/

Б.Энхбаяр: Б.Дэлгэрсайхан гишүүн тодруулж асууя.

Б.Дэлгэрсайхан: Түрүүн цагдаагийн ажилтан хариулах шиг боллоо. Гэр бүлийн хамаарал гэж. Энэ хойд эцэг дагавар хүүхдээ хүчирхийлэх. Энэ манай нийгмийн нэг үзэгдэл болсон. Энэ үнэхээр гамшиг гэж хэлэх юм уу.

Тэгээд энд судалгаа юу байдаг юм? Ерөөсөө аягүй тодорхой бус байна л даа.

Хоёрдугаарт, Хууль зүйн Төрийн нарийн байгаа байх.

Цаашдаа Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулбал яасан юм? Яг энэ хэсэгт.

Ер нь энэ бол нээрээ үнэхээр маш эмгэнэлтэй шүү. Өнөөдөр бид энд яриад сууж байж болно. Бусад хүнд тохиолдож байгаа. Яриад сууж байна. Маргааш бидэнд тохиолдохыг байг гэхгүй шүү дээ. Хүний амьдрал юм чинь энэ чинь.

Тийм учраас энэ дээр нэлээн.../минут дуусав/

Б.Энхбаяр: П.Сайнзориг дарга ажилтай. Явсан байна.

Ц.Сандаг-Очир гишүүн асуултаа асууя.

Ц.Сандаг-Очир: Хүний эрхийн Үндэсний Комисс илтгэлдээ хүүхдийн эрхийг ер нь дотуур байран дахь хүүхдийн эрхийн чиглэлээр хийсэн юм байна гэж ингэж ойлголоо.

Нийтдээ 500 гаруй дотуур байр байдаг юм байна. Улсын хэмжээнд. Тэгээд би Т.Ням-Очир даргаас асуух гэсэн юм.

Цаашдаа төрийн болон төрийн өмчийн сургуулиуд дээр хөдөө, нийслэлгүй эцэг, эхийн хурал гэдэг юмаа, хандлага юмаа өөрчлөх шаардлагатай юм биш үү.

Хагас өнчин хүүхэд байна, бүтэн өнчин хүүхэд байна. Тэр хүүхдүүдийн хувьд эцэг, эхийн хурал зарлагдаад очих хүн байхгүй гэдэг юм уу, тэр хүүхдэд сэтгэл санааны хувьд хэрхэн яаж тусаж байгаа вэ?

Тийм учраас цаашдаа эцэг, эхийн хурал гэдэг юмаа багш нартаа, сургуулиуддаа чиглэл өгч асран хамгаалагчийн гэдэг юм уу, юу гэдэг юм, тэр талаас нь хандлага юмандаа өөрчлөлт оруулах.

Нөгөө талаар эцэг, эхийн сургууль, цэцэрлэгүүдээр эцэг, эхийн дундах тэмцээн гээд учир утгагүй баахан тэмцээнүүд болох юм. Сургалтын байгууллагууд нь хүүхдээ хөгжүүлэх ёстой юм уу, эцэг эхчүүдээ уралдаан

тэмцээнээр нь өрсөлдүүлэх нь үндсэн чиг үүрэг нь юм уу.

Тэгээд эцэг, эхгүй хүүхдүүд нь яах юм. Тэгээд цаашлаад эцэг, эхчүүдийн тэмцээн нь оройдоо эцэг, эхчүүдийн дундах архидалтын нэг үндэс болж байгаа шүү дээ.

Үүнийг Боловсролын яам, Боловсролын ерөнхий газар хэрхэн яаж анхаарч байгаа юм. Энэ эрхлэгч, захирлууддаа хэлж ярьж чиглэл өгдөг юм уу, өгдөггүй юм уу, хорьж болдог юм уу, болдоггүй юм уу. Энэ дээр Та бүхэн ер нь юу гэж бодож байгаа юм бэ гэж.

Энэ дотуур байран дээр гараас гарт үйлчилгээ хэрэгждэг үү, үгүй юу? Өнөөдөр төрийн болон төрийн өмчийн сургуулиуд дээр 1-ээс 4, 5 дугаар анги хүртэл нь асран хамгаалагч нарт нь өглөө орой гараас гарт үйлчилгээ явж байгаа байх. Тийм ээ. Цэцэрлэгүүд дээр хүртэл.

Тэгвэл дотуур байрны хүүхдүүд дээр, тэр дундаа бага ангийн хүүхдүүд дээр нь гараас гарт үйлчилгээ байна уу, байхгүй юу? Энэ дээр хяналт байна уу, үгүй юу? Сургуулиас дотуур байр хүртэлх замд хүүхэд гэмт хэргийн хохирогч болох. Тэртээ тэргүй хараа хяналт сул, дотуур байрыг онилчихсон байгаа шүү дээ. Цаад гэмт хэргийн нөхдүүд чинь. Дотуур байр гээд хаягтай байгаа нь өөрөө хараа хяналт сул. Эцэг, эхчүүдийн асран хамгаалагч нарын сул дорой байдлыг ашиглаж хүүхдүүдийг гэмт хэргийн хохирогч болгох нэг суурь нөхцөл.

Тийм учраас сургуулиуд дээр дотуур байранд чинь ер нь манаачаас өөр, жижүүр багшаас өөр хэн байдаг юм. Яг хүүхдийн эрхийн зөрчлийн асуудлууд дээр хамгаалах эмч гэж байна уу, байхгүй юу?

Олон нийтийн байцаагч, цагдаа гэмт хэрэг зөрчлийн талаас нь хэн байх юм? Тэр жижүүр манаач бүх талын хүүхдийн эрхийг хамгаалаад явах тэр бололцоо боломж нь хэр байдаг юм? Үүнийг Та бүхэн хэлж өгөөч ээ.

Нөгөө талаар сая дүгнэлтэд их ноцтой зөрчил гарч байна. Ж.Хунан даргын. Дотуур байрны охидын өрөөнд камер байсан асуудал гэж. Энэ өөрөө хүний эрхийн хамгаалагчийн тухай хуулиар хориглосон заалт шүү дээ. Нөгөө талаасаа шууд гэмт хэрэг шүү дээ.

Тэгээд энэ цаг үед ийм мэдрэмжгүй, хүний эрхийн мэдрэмжгүй, хүүхдийн эрхийн мэдрэмжгүй ийм захирлууд байдаг гэж үү? Ийм багш нар байдаг гэж үү? Та бүхэн энэ тал дээр ямар арга хэмжээ, таслан сэргийлэх ямар арга хэмжээ авсан юм.

Тэгээд ийм мэдрэмжгүй захирал, эрхлэгч нарыг та нар олон нийтэд зарлах хэрэгтэй шүү дээ. Ийм мэдрэмжгүй, ийм хүний эрхийн өндөр хөгжсөн олон нийтийн зүгээс хүний эрхийн чиглэлээр дуу гаргаж ярьдаг болчихсон цаг үед ингээд охидын өрөөнд ингээд камер.../минут дуусав/

Б.Энхбаяр: Т.Ням-Очир дарга эхлээд хариулъя. 7 номерын микрофон.

Т.Ням-Очир: Ц.Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя.

Сургуулийн дотоод журам, суралцагчийн дүрмүүд дээр бид бусад мэргэжлийн байгууллагуудтай хамтраад хяналт шинжилгээ, зөвлөн туслах үйл ажиллагаа хийж байгаа.

Яг энэ сургуулийн дотоод журам, суралцагчийн дүрэм дээр хүүхдийн

эрхийг хүний эрхийг зөрчсөн зүйл заалтууд байна уу? Уламжлалт хандлагаар явж байгаа. Энэ нь орчин үед нийцэхгүй байгаа ийм асуудлууд байна уу гэдэг дээр нэлээн дүн шинжилгээ хийж ялангуяа 2021-2022 оны хичээлийн жилээс нэлээн засаж залруулах арга хэмжээнүүдийг авч байгаа.

Жишээлбэл, янз бүрийн тэмдэглэлт баяр ёслолыг тохиолдуулаад ээждээ захидал бичээрэй, аавуудын баяр гэдэг ч юм уу ийм арга хэмжээнүүдийн нэр томъёог нь өөрчлөх, арай орчин үеийн чиг хандлагад нийцүүлсэн байдлаар сайжруулах. Дээрээс нь өвлийн хүйтний улиралд хүүхдүүдийг 30-аас 60 минутад ээлж солигдох мөчид гадаа жагсааж дааруулдаг энэ асуудлууд гэх мэтчилэн гээд яг сургуулийн дүрэм, дотоод журамд заасан асуудлуудыг хэдүүлээ цаашдаа дотоод журам, суралцагчийн дүрмээсээ авъя. Үүнийг ингэж ингэж сайжруулъя гэдэг зөвлөмж, чиглэлүүд ер нь өгөгдөөд явж байгаа. Тэгээд сайжирч байгаа, засагдаж байгаа асуудлууд байгаа.

Энэ бол олон жил тогтож ирсэн энэ уламжлалт хандлага, энэ юмыг үүнийг солиход тодорхой цаг хугацаа, шилжилтийн үе шаардаж байгаа. Энэ дээр тухай бүрд нь зөрчил гарч байгаа байгууллага, албан тушаалтан нэг бүрээр нь хянаж ажиллаж байгаа гэдгийг албан ёсоор хэлэх нь зөв байгаа гэж бодож байна.

Дотуур байран дээр тавигдах нийтлэг шаардлагын дагуу үйл ажиллагаанд нь хяналт тавиад үйлчилгээнүүд нь хийгдээд явж байгаа. Жишээлбэл, орой 8 цагаас хойш ч юм уу хүүхдүүдийг хараа хяналтгүй гаргахгүй байх, эцэг, эхчүүд нь ирж аваагүй тохиолдолд амралтын өдрүүдээр зориулалтын бус унаа тэргээр явуулахгүй

байх гэх мэтчилэн яг ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн хүүхдүүдэд үйлчилдэг шиг гараас гарт үйлчилгээ тавигдах шаардлагынхаа дагуу явагдаж байгаа.

Одоо бүр нарийвчлаад бид цаг агаарын аюултай үзэгдлийн үед хүүхдүүдийг эцэг, эх нь ирсэн ч байсан тухайн үед амраагаад явуулах хүртэл нэмэлт зохицуулалтуудыг энэ дээр оруулж байгаа.

Сая Ж.Хунан даргын илтгэлд ч гарлаа. Гарсан кэйс дээр бид намар очиж ажиллахад камергүй дотуур байр байсан.

Камертай байх ёстой гэдэг шаардлага тавиад явахаар камер тавихдаа өрөөн дотор камер тавьчихсан асуудлууд үүсэж байгаа юм. Асуудлыг судлаад үзэхээр захирал нь солигдчихсон. Дотуур байрны ажилчид нь солигдчихсон. Нарийвчилж дүрэм журмаа судлаагүйгээс ийм асуудал гаргачихсан зүйлүүд байсан.

Тэгэхээр гарч байгаа кэйс болгон дээр нь асуудлыг залруулах зөвлөн туслах үйлчилгээнүүдийг өгөөд явж байгаа. Нийтлэгээрээ дүрэм журмаа нарийвчилж судлах, дотуур байрны багшаас эхлээд ажилтан, албан хаагч хүртэл сургалтын модулиуд гарсан. Сургалтууд зохион байгуулагдаж явж байгаа гэдгийг албан ёсоор хэлэх нь зүйтэй болов уу гэж бодож байна.

Б.Энхбаяр: Ц.Сандаг-Очир гишүүн тодруулж асууя.

Ц.Сандаг-Очир: Яах вэ, арга хэмжээнүүд авагдаад сайжирч байгаа юм байна л гэж ойлгоё. Тэгээд амьдрал дээр өөр шүү.

Нөгөө талаас би Байнгын хорооны даргад манай Нийгмийн бодлогын

байнгын хороотой хамтарч хийсэн бол илүү үр дүнтэй байх байжээ.

Манай Хууль зүйн байнгын хороонд чинь ганцхан эмэгтэй гишүүн байдаг. Нийгмийн бодлогын байнгын хороонд яг энэ хүүхдийн эрх, хөдөлмөрлөх эрх, ахмад настны эрх гээд яг энэ Хүний эрхийн Үндэсний Комиссын тавьсан тайлан илтгэлтэй холбогдуулж Нийгмийн бодлогын байнгын хорооныхон илүү идэвхтэй асуудалд хандах байсан байна.

Тэгээд дараа дараа бас анхаарах ёстой юм байна гэж бодож байна. Баярлалаа.

Б.Энхбаяр: Улсын Их Хурлын бүх гишүүд аль ч Байнгын хорооны хуралдаанд оролцох эрхтэй.

Хүний эрхийн тайлан илтгэл хэлэлцэж байгаатай холбоотой нийт Улсын Их Хурлын гишүүдэд энэ Хууль зүйн байнгын хорооны. Би тодотгож хашилтад хэлж байгаа. Хагас сонсгол хэлбэрээр тайлан сонсож байгаа. Энд урьсан байгаа.

Мөн Байнгын хорооны дараа Улсын Их Хурлын нэгдсэн чуулган дээр энэ асуудал яригдана гэдгийг нэмж хэлье.

Б.Энх-Амгалан гишүүн асуултаа асууя.

Б.Энх-Амгалан: Та бүгдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Хүүхдийн эрхийн асуудлаар би Та бүгдийн өгсөн тоон дээр л ярья л даа.

2018 онд хүүхэд хохирсон гэмт хэрэг 1688 гарсан байна. Тэгсэн чинь 2022 онд энэ тоо 2014 болоод өсчхөж.

Амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг 230, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 2525, хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 1850, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 2088 гээд. Энэ тоо чинь сүүлийн 5 жилээр ингээд өсөөд яваад байна.

Тэгээд бид нэг гоё юм яриад суугаад байх юм. Нэг статистик тоо барьчхаад л.

Тэгээд бүх юм нь ингээд хаа гуяараа салчихсан юм шиг ингээд тусдаа. Тэгээд яаж байна гэхээр зэрэг эхний 3 сарын байдлаар бэлгийн хүчирхийллийн асуудал 80 гарсан. Энэ эхний 3 сарын байдлаар 17 хувь өслөө гээд нэг тоо яриад л.

Тэгээд л бид соён гэгээрүүлэх ажил хийж байгаа, сургалт хийж байгаа, үүнийг тогтмолжуулж байгаа, зохион байгуулж байгаа гээд л.

Тэгээд л шагнал, шалгалтыг их сайхан хийж байгаа. Хяналт шинжилгээг чиглэлийн байгууллагуудтай хамтарч хийж байгаа. Зөвлөн туслах ажлыг хийж байгаа гээд. Хийж байгаа юм энэ чинь яагаад гэмт хэрэг чинь буурахгүй байгаа юм.

Ийм нэг статистик ярьдгаа бид болимоор байгаа байхгүй юу. 12 мянга 43 үр хөндөлсөн тохиолдол байна. Энэ бол өмнөх оны мөн үеийнхээс 26 хувь буурсан юм гээд.

Тэгэхээр өмнөх онд хэд байсан юм. 18 мянга байсан юм уу? Энэ чинь аймшигтай тоо биш үү. 3-хан сая хүнтэй Монгол Улсын хувьд энэ үр хөндөлт чинь аймшигтай тоо биш юм уу.

Тэгээд уламжлалт хандлагаа солиод аавын тухай захиа бичиж болохгүй гээд ийм юм яриад сууж байдаг. Аавтай байсан ч захиа бичнэ, аавгүй байсан ч захиа бичнэ шүү дээ. Би аавтай байсан бол ингэнэ гэж захиа бичдэг юм байгаа биз дээ. Тэр хүүхэд чинь.

Тэгээд хүний эрхийн сургалт явуулна гээд юм яриад байх юм. Хүний эрхийн сургалт биш хүн болгох сургалт явуулахгүй юм уу? Монгол хүн болгох, аав ээжээ, ах дүүгээ, амраг саднаа, найз нөхдөдөө хайрладаг Монгол хүн болгох сургалт явуулахгүй юм уу?

Би энэ дээр юу ярих гэж байна гэхээр зэрэг хар тамхин дээр ч тэр, энэ хүүхдийн эрхийн асуудал дээр ч тэр, хүний эрхийн асуудал дээр ч тэр дандаа ийм хаа гуяараа салчихсан нэгдмэл дүнгүй зөрүүтэй статистик барьсан ийм юм орж ирдгээ жоохон болимоор байна.

Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл байгуулмаар байх юм. Ерөнхий сайдын дэргэд байдаг юм уу, эсвэл аль сайдынх нь дэргэд байдаг юм.

Тэгээд энэ үндэсний зөвлөл үндэсний хэмжээнд ажиллахгүй бол одоо энэ чинь гамшиг боллоо шүү дээ. Одоо энэ хүүхдийн амьдрах орчин зөвхөн дотуур байр биш. Сургуулийн орчин, тэр парт ширээ, өнцөг булан. Энэ чинь хүүхэд унаад л нүдээ гэмтээх, гараа хугалах ийм юмнууд болчихоод байна шүү дээ.

Хүнсний асуудал. Эрүүл хүнс хэрэглэх асуудал байгаа юм. Үдийн хоолны хөтөлбөр чинь маш хүнд. Одоо дотуур байранд байгаа хүүхдийг чинь хөдөө суманд 5 мянган төгрөгөөр ямар хоол өдрийн 3 удаа идэх юм бэ.

Тэгээд энэ гэр бүлийнх нь асуудал. Ээж нь ирээд суучихдаг. Аав нь хөдөө байж байдаг. Тэгээд гэр бүлийн салалт үүсдэг.

Сургалтын асуудал. Багш нарын чинь цалин бага учраас хүн ирэхгүй. Үүнийг яаж цогцоор нь шийдэх юм.

Нийт гэмт хэргийн чинь 86 хувь нь цахим дээр үйлдэгдэж байна шүү дээ. Тэгээд бүх багш нар нь цахим даалгавар өгөөд байхаар энэ юу болох юм бэ?

Ийм учраас энэ дээр яг яах юм бид нар. Хүний эрхийн Үндэсний Комисс энэ дээр ямар саналтай байгаа юм?

Үүнийг бид цогцоор нь барьж шийдэхгүй бол ингээд нэг нэгээр нь шийдээд юу ч явахгүй. Хүүхдүүд хүчирхийлүүлсээр байх болно.

Тэгээд одоо зүгээр ингээд хүүхдийн эсрэг бэлгийн гэмт хэрэг эхний 3 сард 80 гарлаа. Энэ бол 17 хувиар өслөө гээд ийм тоо бид яриад сууж болохгүй биз дээ. Энэ чинь одоо.

Хатуу хариуцлага тавьж байх ёстой шүү дээ. Хуульдаа өөрчлөлт оруулж байх ёстой шүү дээ. Нийгмээр энд чинь анхаарахгүй болохоо байлаа шүү дээ.

Б.Энхбаяр: Б.Энх-Амгалан гишүүн нэлээн бодлогын асуудлууд асууж байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам энэ гэр бүл хүүхдийн бодлогын асуудлыг хариуцдаг. Дэд сайд С.Зулпхар хариулах нь зүйтэй байх. 5 номерын микрофон.

С.Зулпхар: Б.Энх-Амгалан гишүүний асуултад хариулья.

Гэр бүл, хүүхэд залуучуудын бодлого салбар дундын шинжтэй үйл ажиллагаа гэдгийг Та бүхэн илэрхийлж байна. Энэ бол үнэн.

Нэг талаар хүүхдийн эрх сургуулийн орчинд, гэр бүлийн орчинд, түүнээс гадна жишээ нь бусад орчинд хангагдах ёстой. Бас хамгаалал нь энд хангагдах ёстой гэдэг ийм бодлого бид баримталж байгаа.

Хүүхдийн эрхтэй холбоотой асуудлыг Монгол Улсын Ерөнхий сайд хүүхдийн эрхийг хамгаалах гол үндсэн байгууллага Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийг даргалдаг учраас энэ дээр гол бодлогыг зангидаж байгаа гэдгийг хэлье.

Саяын гаргасан хүүхдийн эрхийн зөрчилтэй холбоотой статистикууд ер нь саяын гурав, дөрвөн салбарын хувьд үндэсний нэгдмэл байгаа. Бидэнд байгаа мэдээллүүд.

Саяын гэмт хэрэгтэй холбоотой, гэмт хэрэгт холбогдсонтой холбоотой. Түүнээс гадна хүчирхийлэлд өртсөнтэй холбоотой, хүчирхийллээс хамгаалуулсантай холбоотой бүх статистикууд нэгдмэл бодлогоор байгаа гэдгийг хэлье.

Статистик тоо өөрөө өсөж байгаа нь үнэн. Тухайлбал, өнгөрсөн жил гэхэд 108 гэдэг утсанд 111 мянган дуудлага ирсэн байна. 111 мянган дуудлага байнга хүүхдийн эрхийн зөрчлөөс гадна хүүхэд тодорхой асуудлаар зөвлөгөө авах, цаг үе, нийгмийн өөрчлөлттэй холбоотой ийм дуудлагууд байдаг учраас энэ дээр хариу үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа явагдаж байгаа гэдгийг хэлье.

Хүүхдийн эрхийг нэгдүгээрт урьдчилан сэргийлэх чиглэлээр хийх үйл

ажиллагааны хэлбэрээр бодлого болон зохицуулалтууд нь хийгдэж байгаа. Энд төрийн байгууллагад өөрсдөө чиг үүргээрээ тодорхой үүрэг хүлээдэг.

Хоёрдугаарт, хүүхдийн эрхийн зөрчил гарсан нөхцөлд энэ зөрчил дээр нь кэйс менежментээр ажиллах ийм ажил хийгддэг байгаа юм.

Ингээд энэ хоёр ажлын хүрээнд одоо жишээ нь хүүхдийн эрхийг хангах ажлууд тухайлан хийгдэнэ.

Нөгөөтээгүүр эрх зөрчигдсөн хүүхдэд үйлчилгээ үзүүлэх ийм кэйс менежментийн ажлууд хийгдэг.

Хүүхдийн эрх, хүүхдийн хамгаалалттай холбоотой Монгол Улсын Их Хурлаас төсвийг өнгөрсөн жилүүдэд нэмэгдүүлж ирсэн. Та бүхэн мэдэж байгаа байх өнгөрсөн 2 жилд 8 тэрбум төгрөг баталсан. Үүнийг жишээ нь яг саяын кэйс менежментээр эрх нь зөрчигдсөн хүүхдүүд дээр ажиллаж байгаа гэдгийг хэлье.

Орчинтой холбоотойгоор шинэ нөхцөл байдлууд бий болж байна. Сургуулийн орчинд сая манай Боловсрол, шинжлэх ухааны яамныхан хэлж байна. Хүүхэд, хүүхдийн эрхийг зөрчих нөхцөл байдлууд их гарч байна. Үе тэнгийнхны дээрэлхэлт гэдэг ийм үзэгдэл нэлээн газар авах шинжтэй байгаа.

Энэ дээр манай жишээ нь Гэр бүл, хүүхэд залуучуудын газар болон Боловсрол, шинжлэх ухааны яам хамтарсан байдлаар бид сургуулиудаар ажиллаж байна.

Өөрөөр хэлбэл хүүхэд бие биеэ хайрлах, бие биеийнхээ эрхийг зөрчихгүй байх чиглэлээрх энэ ажлуудыг хамтарч хийж байгаа гэдгийг хэлье.

Цаашлаад яах вэ олон улсын байгууллагууд ч гэсэн нэн ялангуяа Хүүхдийн сан, хүүхэд хамгааллын олон улсын бусад байгууллагууд энд зохих түвшний үүрэг хүлээж байгаа.

Засаг захиргааны нэгжид Засаг дарга нар энэ хүүхэд хамгаалал дээр шууд үүрэг хүлээдэг. Хүүхдийн эрхийг салбар хорооны даргын үүргийг хүлээдэг учраас орон нутагт засаг захиргаанд энэ хамгаалах ажлыг бүрэн өөрөө зохион байгуулах үүрэг хүлээж байгаа юм.

Б.Энхбаяр: Б.Энх-Амгалан гишүүн тодруулж асууя.

Б.Энх-Амгалан: Би нэг юм хэлээд байна шүү дээ.

Кэйс менежмент хийгээд байгаа 8 тэрбум төгрөг зарсан. Хамтраад бид сайхан шалгаад байгаа, хяналтын мониторинг хийгээд байгаа, соён гэгээрүүлээд байгаа, сургалт явуулаад байгаа, зөвлөн туслаад байгаа гээд.

Үгүй тэгээд зөвлөн туслаад юм хийгээд байгаа юм энэ гэмт хэрэг чинь яагаад өсөөд байгаа юм бэ? Яагаад сургуулийн орчинд үйлдэгдэж байгаа, цахимаар үйлдэгдэж байгаа, хүүхдүүдийн дунд үйлдэгдэж байгаа гэмт хэрэг чинь өсөөд байгаа юм бэ?

Ажлаа сайн хийгээд та нар ийм нэгдсэн байдлаар яваад байгаа юм бол яагаад энэ чинь нэмэгдээд байгаа юм бэ л гэж би асуугаад байна шүү дээ.

Тэгээд үүнийгээ яаж цогцоор нь зохион байгуулах юм бэ гэхээр зэрэг л өмнөөс тайлан тавиад суугаад байх юм.

Хэрвээ та нар сайн ажиллаж байгаа бол энэ үзүүлэлт чинь буурч байх

ёстой биз дээ. Энэ 12 мянган үр хөндөлт чинь багасаж байх ёстой биз дээ. Оны эхний байдлаар 80 хүчирхийлэл гарч байгаа юм чинь одоо тэг болж байх ёстой биз дээ. Тийм л юм хийгээд байгаа юм бол.

Би та нараас тайлан сонсох гээгүй байна шүү дээ. Цаашдаа төрийн бодлого яаж явах юм бэ гэдгийг л хэлээд өг л дөө.

Б.Энхбаяр: Хүчирхийллийн эсрэг үндэсний төвөөс хүн байна уу? Ж.Хунан дарга хариулах юм уу? Нийгмийн, сэтгэл зүйн асуудал хөндөөд байна шүү дээ. С.Зулпхар дэд сайд хариулья. 5 номер.

С.Зулпхар: Б.Энх-Амгалан гишүүний асуултад хариулья.

Хүүхдийн эрх, хүүхэд хамгаалалттай холбоотой бодлого болон зохицуулалт огт байхгүй биш. Тодорхой жишээ нь механизмууд байхгүй биш. Гэхдээ таны саяын хэлсэн шүүмжлэл дагуулах гарцаа байхгүй сэтгэл сэрдхийлгэх ийм нөхцөлүүд бий болсоор байгаа гэдгийг хэлье.

Гэлээ гэхдээ яг одоо үүнтэй холбоотой өнгөрсөн хугацаанд бид хүүхдийн эрх хамгаалалтай холбоотой тогтолцоонд үнэлгээ хийгдсэн. Энэ үнэлгээний дагуу манай тогтолцоо өөрөө хоорондоо уялдахгүй байна гэдэг дүгнэлт маш тодорхой гарсан.

Үүний дагуу бидэнд өгөгдсөн зөвлөмжийн дагуу нэгдүгээрт Хүүхдийн эрхийн тухай хуулийг шинэчлэх ёстой юм байна.

Хоёрдугаарт, Хүүхэд хамгааллын тухайн хуулийг шинэчлэх юм байна гэж.

Хүүхэд хамгааллын хууль нь өөрөө дотроо жишээ нь энэ тогтолцооны

бүрэлдэхүүн хэсэг болсон төрийн байгууллагууд, гэр бүл, эцэг, эх, цаашлаад жишээ нь бусад асран хамгаалагчдын түвшний эрх болон зохицуулалтыг нарийвчилж өгөх ийм шинжтэй шинэ бодлогын хууль орж ирж байгаа гэдгийг Танд хэлье.

Нөгөөтээгүүр Ерөнхий сайдын зүгээс чиглэл.../минут дуусав/

Б.Энхбаяр: Гишүүд асуулт асууж дууслаа.

Хүүхдийн эрхийн зарим асуудал сэдвийн хүрээнд үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү.

Б.Энх-Амгалан гишүүнээр тасаллаа. Б.Энх-Амгалан гишүүн үгээ хэлье.

Б.Энх-Амгалан: Бид бүгдээрээ эцэг, эхчүүд байхгүй юу. Бидний үр хүүхэд энэ нийгэмд амьдарна.

Тэгээд энэ үр хүүхдүүдийнхээ хойноос бид санаа зовохгүй юм бол бид сайхан нийгмийг хойч үедээ үлдээж чадахгүй.

Тэгэхээр бид өнөөдөр ингээд нэг тайлан хамгаалсан болоод, нэг статистик тоо ярьсан болоод, тэгээд би тэгсэн, манайхан тэгсэн, олон улсын байгууллага хариуцлага хүлээж байгаа, кэйс менежмент хийж байгаа, тэгж байгаа гээд хэрэггүй.

Хэрвээ бид үр дүнтэй сайн ажиллаж байгаа бол, сэтгэл гаргаж ажиллаж байгаа бол энэ тоо чинь өөрөө буурч байх ёстой юм. Энэ төрөлт чинь нэмэгдэж байх ёстой юм. Хүүхдийн дундах хүчирхийлэл багасаж байх ёстой юм.

Зүй нь та хэд маань яг үүнийг цогцоор нь шийдэхийн тулд гэр бүлийн багц хууль оруулж ирэх ёстой гэж би бодож байна.

Эцэг, эхийг нь яах юм, хүүхдийг нь яах юм, сургуулийн орчныг нь яах юм, багшийг нь яах юм. Яг энэ хүний чинь энд амьдарч байгаа нийгэмд оруулж байгаа энэ багц хуулийн асуудлуудыг одоо энэ төрийн холбогдох яамд нийлж байгаад та нар тийм бодлогоо нийлүүлээд л мундаг байгаа юм бол үүнийгээ л оруулж ирмээр байгаа байхгүй юу.

Тэгэхгүй тэгээд л одоо бид энэ тооноосоо бүр ажиггүй ярьдаг болсон байна шүү дээ. 12 мянган хүүхэд үр хөндөлт хийлгэсэн. Энэ ч яах вэ, 26 хувь буурч байгаа юм гээд л. Энэ чинь аюул шүү дээ. Багаасаа хүчирхийлэлд өртчихсэн хүн чинь тэр чигээрээ насан туршийн тархинд нь үлдчихэж байгаа байхгүй юу. Тэрнээс айна, цочно, хүнийг ад үздэг болно. Нийгмийн хамгийн аюултай хүн тэндээс бий болно шүү дээ.

Тэгэхээр үүнийг хийх тал дээр Ж.Хунан дарга анхаараач.

Тэгээд цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалъя гэхээр тэрийг нь таслан зогсоох ажил явуулахаар үүнийгээ эсэргүүцдэгээ болиорой та нар. Энэ маш чухал асуудал шүү.

Бид хэд хэдэн чухал асуудал хөндөхөөр гаднын санхүүжилттэй төрийн бус байгууллагын хатгаасаар хөдөлдөгөө болиорой. Монгол хүн юм бол дотроо юмаа бодож байгаарай. Авдраа ухаарай. Тэр гаднын зөвлөхүүд яах вэ.

Монголчуудын үр хүүхдээ хүмүүжүүлдэг арга ажиллагаа өөр шүү. Үр хүүхдээ сургадаг, дадлагажуулдаг, ухаан суулгадаг, ажил хөдөлмөрт дуртай

болгодог, эх орондоо, газар шороондоо, аав ээждээ, ах дүүдээ хайртай болгодог арга ажиллагаа сургалт өөр шүү. Энэ үндэснийхээ юм руу жоохон явах ёстой шүү. Тэгж байж юм их цэгцэрнэ.

Тэгээд үүнийг цогцоор нь ийм хууль оруулж ирж ингэж хийгээсэй гэж би та бүхнээс хүсэж байна.

Түүнээс хаа гуяар нь яриад, нэг цонхны шил яриад, наалт яриад, хөшиг яриад, ганц камер яриад энэ асуудал шийдэгдэхгүй. Цогцоор нь шийдье гэвэл Гэр бүлийн багц хуулийг оруулж ирж байж бид ярих ёстой. Цөмөөрөө ярих ёстой.

Энд орхигдох хүн гэж байхгүй. Энд хэн нэгийг нь яллах гээгүй, хэн нэгнийг буруушаах гээгүй.

Хамгийн гол нь энд бүгдээрээ ярьж байж шийдэхгүй бол болохгүй асуудал их олон байна гэдгийг л бид

хараад байгаа юм. Үүнийг Та бүхэн маань анхаараарай. Баярлалаа.

Б.Энхбаяр: Хүүхдийн эрхийн зарим асуудлын сэдвийн хүрээнд тавьсан тайлантай холбоотойгоор гишүүд үг хэлж дууслаа.

Ажлын цаг дууссан байна. Бид чинь хөдөлмөрлөх эрхийн тухай ярьж байгаа учраас бас энэ эрхийнхээ хүрээнд, ажлын цагийн хүрээндээ хүндэтгэлтэй хандаж асуудлаа хэлэлцэх ёстой.

Тийм учраас өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх байсан Ахмадын эрхийн асуудал, мөн Улс төрийн хүрээнд дэх жендэрийн эрх тэгш байдлын асуудлыг маргааш өглөө 10.00 цагаас Хууль зүйн байнгын хорооны хуралд эхний асуудлаар хэлэлцэж үргэлжлүүлнэ.

Өнөөдрийн хуралдаан дууссаныг мэдэгдье. Баярлалаа. /алх цохив/

Хуралдаан 2 цаг 51 минут үргэлжилж, 17 цаг 41 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД